





ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠣᠷᠤᠨ ᠰᠤᠤᠴᠨᠢ
ᠲᠤᠨᠤᠯᠯᠣᠭ᠎ᠠ
ᠲᠤᠨᠤᠯᠤᠰᠤ
ᠲᠤᠨᠤᠯᠤᠰᠤ
ᠲᠤᠨᠤᠯᠤᠰᠤ

ХҮН АМЫН 2010-2040 ОНЫ ХЭТИЙН ШИНЭЧИЛСЭН ТООЦОО





МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ХҮН АМЫН 2010-2040 ОНЫ
ХЭТИЙН ШИНЭЧИЛСЭН ТООЦОО

Улаанбаатар хот
2013 он

DDC
310
X-822

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
<http://www.nso.mn>
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

Хүн амын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцооны
үр дүнг дэлгэрэнгүй байдлаар
www.1212.mn,
arcgis.nso.mn
сайтаас авна уу.



Үндэсний Статистикийн Хорооны
Мэдээллээр үйлчлэх төвийн
хэвлэлийн цехэд хэвлэв.
Tel: 326414

ISBN 978-99929-907-9-1

АГУУЛГА

Сэдэвчилсэн судалгааг бичихэд оролцогчид.....	4
Хүснэгт, зургийн жагсаалт.....	5
Товчилсон үгийн тайлбар.....	8
Ойлголт, тодорхойлолт.....	9
Өмнөх үг.....	10
Удиртгал.....	11
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭТИЙН ТООЦОНЫ АРГА ЗҮЙ.....	13
1.1. Хэтийн тооцооны арга зүй	
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭТИЙН ТООЦОНЫ СУУРЬ ХҮН АМЫН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ.....	19
2.1. Суурь хүн амын нас, хүйсийн бүтцийн үнэлгээ.....	20
2.2. Хүн ам нэг наснаас нөгөө насанд шилжин амьдрах магадлалын (рх) шинжилгээ.....	23
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЭТИЙН ТООЦОНЫ ТӨСӨӨЛӨЛ, ТААМАГЛАЛ.....	27
3.1. Төрөлтийн таамаглал.....	28
Улсын түвшний төрөлтийн таамаглал.....	28
Бүс, аймаг, нийслэлийн түвшний төрөлтийн таамаглал.....	31
3.2. Нас баралтын таамаглал.....	32
Улсын түвшний нас баралтын таамаглал.....	32
Бүс, аймаг, нийслэлийн нас баралтын таамаглал.....	33
3.3. Шилжих хөдөлгөөний таамаглал.....	35
Дотоод шилжих хөдөлгөөний таамаглал.....	35
Гадаад шилжих хөдөлгөөний таамаглал.....	37
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМЫН ХЭТИЙН ТООЦОНЫ ҮР ДҮН.....	41
4.1. Хүн амын тоо, өсөлтийн хурд.....	42
4.2. Хүн амын нас, хүйсийн бүтэц.....	44
4.3. Төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний төлөв байдал.....	50
4.4. Зорилтот бүлгийн хүн амын тооны өөрчлөлт.....	51
4.5. Аймаг, нийслэлийн хэтийн тооцооны үр дүн.....	56
ДҮГНЭЛТ. ЗӨВЛӨМЖ.....	64
Ном зүй.....	65
ХАВСРАЛТ.....	67
Хавсралт 1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амд үндэслэсэн улсын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо, хувилбар тус бүрээр.....	67
Хавсралт 2. Монгол Улсын хүн амд үндэслэсэн улсын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо, хувилбар тус бүрээр.....	101
Хавсралт 3. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амд үндэслэсэн аймаг, нийслэл, бүсийн хүн амын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо, хувилбар тус бүрээр.....	135
Хавсралт 4. Монгол Улсын хүн амд үндэслэсэн аймаг, нийслэл, бүсийн хүн амын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо, хувилбар тус бүрээр.....	179
Хавсралт 5. Хүн ам зүйн ачаалал, аймаг, нийслэл, бүсээр 1Б, 2Б хувилбараар.....	223

СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААГ БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Жүгдэрийн Мөнхбадар

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга

Тогтоогийн Алтанцэцэг

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

Бямбацогтын Уранбилэг

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

Түвшинтөрийн Жаргалсайхан

Эдийн засагч-Хүн ам зүйч
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ажилтан

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг

Хүн ам зүйн ухааны магистр
ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ажилтан

ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

Баатарын Эрдэнэсүрэн

Үйлдвэрийн инженер-Эдийн засагч,
Эдийн засгийн ухааны доктор, профессор
ҮСХ-ны дэд дарга

Цэнджавын Бадрах

Эдийн засагч
ҮСХ-ны зөвлөх

ГУРАВ. АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН

Авирмэдийн Амарбал

Эдийн засагч-Хүн ам зүйч, Хүн ам зүйн ухааны доктор
ҮСХ-ны Шинжилгээ, судалгааны газрын дарга

Рикардо Ньюперт

Олон улсын зөвлөх

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.1.	Хэтийн тооцооны арга зүйн харьцуулалт	15
Хүснэгт 1.1.2.	Хэтийн тооцоо хийхэд ашигласан мэдээлэл болон програмууд	16
Хүснэгт 1.1.3.	Төрөлтийн ойролцоо түвшнээр тооцсон ТНК, бүлэг, аймаг, нийслэлээр	17
Хүснэгт 2.1.1.	Суурь хүн амын нас, хүйсийн бүтцийн индексийн шинжилгээ, аймаг, нийслэлээр, 2010 он	23
Хүснэгт 2.2.2.	Тооллого, захиргааны статистик мэдээлэл хоорондын 10-аас доош насны хүн амын тооны харьцуулсан шинжилгээ, 2010 он	26
Хүснэгт 3.1.1.	Таамагласан төрөлтийн нийлбэр коэффициент, бүлэг, хувилбараар, 2010-2040 он ..	31
Хүснэгт 3.2.1.	Хүн амын дундаж наслалт, ложистикийн аргаар, хүйсээр, 2010-2040 он	32
Хүснэгт 3.2.2.	Таамагласан дундаж наслалт, бүлэг, хүйсээр, 2010-2040 он	34
Хүснэгт 3.3.1.	Хүн амын дотоод цэвэр шилжих хөдөлгөөний таамаглал, бүлэг, хүйсээр, 2010-2040 он	36
Хүснэгт 3.3.2.	Хүн амын гадаад шилжих хөдөлгөөний мэдээлэл, 2000-2010 он	37
Хүснэгт 3.3.3.	Гадаад шилжих хөдөлгөөний таамаглал, 2010-2040 он	38
Хүснэгт 3.3.4.	Гадаад цэвэр шилжих хөдөлгөөний таамаглал, бүлэг, хүйсээр, 2010-2040 он	39
Хүснэгт 4.1.1.	Хүн амын тоо, хувилбар бүрээр, 2010-2040 он	43
Хүснэгт 4.1.2.	Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, хувилбар бүрээр, 2010-2040 он	44
Хүснэгт 4.2.1.	Хүн амын насны бүлэг дэх хувийн жин, "1Б" хувилбараар, 2010-2040 он	45
Хүснэгт 4.2.2.	Хүн амын насны бүлэг дэх хувийн жин, "2Б" хувилбараар, 2010-2040 он	46
Хүснэгт 4.2.3.	Хүн амын хүйсийн харьцаа, насны бүлэг, "1Б" хувилбараар, 2010-2040 он	47
Хүснэгт 4.2.4.	Хүн амын хүйсийн харьцаа, насны бүлэг, "2Б" хувилбараар, 2010-2040 он	47
Хүснэгт 4.2.5.	Хүн амын насны бүтцийн зарим голлох үзүүлэлтүүд, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	49
Хүснэгт 4.4.1.	Нэгдүгээр ангид элсэн орох насны хүн амын тоо, хүйсээр, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	52
Хүснэгт 4.4.2.	Хөдөлмөрийн насанд орох болон гарах насны хүн амын тоо, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	53
Хүснэгт 4.4.3.	Тэтгэврийн насны хүн амын тоо, хүйсээр, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	54
Хүснэгт 4.4.4.	Хөдөлмөрийн насны хүн амаар тооцсон ачаалал, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	55
Хүснэгт 4.4.5.	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	55
Хүснэгт 4.4.7.	Төрөх хүүхдийн тоо, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	56
Хүснэгт 4.5.4.	Аймаг, нийслэлийн хүн амын хэтийн тооцооны үр дүн, "1Б" хувилбараар, 2010-2040 он	57
Хүснэгт 4.5.5.	Аймаг, нийслэлийн хүн амын хэтийн тооцооны үр дүн, "2Б" хувилбараар, 2010-2040 он	58
Хүснэгт 4.5.6.	Хүн амын хүйсийн харьцаа, аймаг, нийслэл, "1Б" хувилбараар, 2010-2040 он	59
Хүснэгт 4.5.7.	Хүн амын хүйсийн харьцаа, аймаг, нийслэл, "2Б" хувилбараар, 2010-2040 он	60
Хүснэгт 4.5.8.	Хүн ам зүйн ачаалал, аймаг, нийслэл, "1Б", "2Б" хувилбараар, 2010-2040 он	61

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.1.	НҮБ-ын нас, хүйсийн индекс, 1963-2010 он	20
Зураг 2.1.2.	Випплийн индекс, 1963-2010 он.....	21
Зураг 2.1.3.	Мэрийн холимог индекс, 1963-2010 он	22
Зураг 3.1.1.	Хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2010 он.....	29
Зураг 3.1.2.	Таамагласан төрөлтийн нийлбэр коэффициент, хувилбараар, 2010-2040 он	30
Зураг 3.1.3.	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, хувилбараар, 2005-2010, 2040 он.....	30
Зураг 3.1.4.	Төрөлтийн дунд бууралттай хувилбарын насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, бүлгээр, 2010, 2040 он.....	32
Зураг 3.2.1.	Эрэгтэйчүүдийн нас барах магадлал, насаар, 2000, 2040 он.....	33
Зураг 3.2.2.	Эмэгтэйчүүдийн нас барах магадлал, насаар, 2000, 2040 он.....	33
Зураг 3.2.3.	Нас барах магадлал, бүлэг, нас, хүйсээр, 2010, 2040 он	35
Зураг 3.3.1.	Дотоод цэвэр шилжих хөдөлгөөнд оролцогчдын нас, хүйсийн бүтэц, 2010 он	37
Зураг 3.3.2.	Шилжих хөдөлгөөнд оролцогчдын нас, хүйсийн суварга, шилжин ирсэн болон явсан хүний зөрүү, хувийн жингээр, 2010-2040 он	38
Зураг 4.1.1.	Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, “1Б”, “2Б” хувилбараар, 2010-2040 он	42
Зураг 4.2.1.	Хүн амын нас, хүйсийн суварга, “1Б”, “2Б” хувилбараар, 2010, 2040 он.....	48
Зураг 4.2.2.	Хүн ам зүйн ачаалал, “1Б”, “2Б” хувилбараар, 2010-2040 он	48
Зураг 4.3.1.	Төрөлтийн ерөнхий коэффициент, “1Б”, “2Б” хувилбараар, 2010-2040 он	50
Зураг 4.3.2.	Нас баралтын ерөнхий коэффициент, “1Б”, “2Б” хувилбараар, 2010-2040 он	50
Зураг 4.3.3.	Гадаад цэвэр шилжих хөдөлгөөний ерөнхий коэффициент, “1Б” хувилбараар, 2010-2040 он	51

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хувилбар 1А:	
Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон, төрөлтийн аажим бууралттай үеийн хүн амын тоо, улсын дүн, нас, хүйс, таван жилээр, 2010-2040 он	68
Хувилбар 1Б:	
Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон, төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын тоо, улсын дүн, нас, хүйсээр, 2010-2040 он	73
Хувилбар 1В:	
Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон, төрөлтийн хурдацтай бууралттай үеийн хүн амын тоо, улсын дүн, нас, хүйс, таван жилээр, 2010-2040 он.....	95
Хувилбар 2А:	
Монгол Улсын хүн амын хувьд тооцсон, төрөлтийн аажим бууралттай үеийн хүн амын тоо, улсын дүн, нас, хүйс, таван жилээр, 2010-2040 он	102
Хувилбар 2Б:	
Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон, төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын тоо, улсын дүн, нас, хүйсээр, 2010-2040 он	107
Хувилбар 2В:	
Монгол Улсын хүн амын хувьд тооцсон, төрөлтийн хурдацтай бууралттай үеийн хүн амын тоо, улсын дүн, нас, хүйс, таван жилээр, 2010-2040 он	129
Монгол улсын нутаг дэвсгэр дэх хүн амд үндэслэсэн аймаг, нийслэл, бүсийн хүн амын тоо, хувилбар тус бүрээр	136
Хувилбар 1Б:	
Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон, төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын тоо, аймаг, нийслэл, хүйс, насны бүлгээр, 2010-2040 он.....	138
Монгол улсын хүн амд үндэслэсэн аймаг, нийслэл, бүсийн хүн амын тоо, хувилбар тус бүрээр	180
Хувилбар 2Б:	
Монгол Улсын нийт хүн амын хувьд тооцсон, төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын тоо, аймаг, нийслэл, хүйс, насны бүлгээр, 2010-2040 он	182
Хүн ам зүйн ачаалал, бүс, аймаг, нийслэл, бүсээр 1Б, 2Б хувилбараар.....	223

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МХИ	Мэрийн холимог индекс
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
НБТК	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБНХИ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын нас, хүйсийн индекс
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАЗА	Хүн ам зүйн ачаалал

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Нас, хүйсийн бүтэц: Насны бүлэг тус бүр дэх эрэгтэй, эмэгтэй хүн амын тоог хувийн жингээр илэрхийлнэ. Хүн амын нас, хүйсийн бүтэц нь төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний өнгөрсөн үеийн чиг хандлагын өсөн нэмэгдсэн үр дүн юм.

Хүйсийн харьцаа: Эрэгтэй хүн амын тоог эмэгтэй хүн амын тоонд харьцуулсан харьцаа бөгөөд энэ нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлнэ.

Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүтцээр илэрхийлнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент: Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшинг илэрхийлнэ.

Төрөлтийн нийлбэр коэффициент: Нэг эмэгтэйн (нөхөн үржихүйн амьдралын хугацаагаа дуустал нас барахгүй гэж үзвэл) нөхөн үржихүйн амьдралынхаа сүүл үе гэхэд төрүүлсэн байх нийт хүүхдийн тоог илэрхийлнэ. Төрөлтийн нийлбэр коэффициентийг бүх эмэгтэй тухайн цаг үе дэх төрөлтийн тоог нэгтгэн, нэг эмэгтэйд ногдохоор тооцдог.

Нас баралтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Насны бүлэг дэх нас баралтын коэффициент: Тухайн насны бүлгийн нас баралтын түвшинг илэрхийлнэ.

Дундаж наслалт: Төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) хэлнэ.

Дотоод шилжих хөдөлгөөн: Тухайн улс, орны хилийн хүрээн доторх засаг захиргааны нэгж хоорондох, түүнчлэн байршлын хувьд (хот, хөдөө) явагдах хүн амын суурьшлын өөрчлөлтөөр тодорхойлогдоно. Шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлт нь шилжин ирэгчдийн тоо, шилжин явагчдын тоо болно.

Гадаад шилжих хөдөлгөөн: Өөр улс орноос тухайн улсад шилжин ирэгчид болон тухайн улсаас өөр улс руу шилжин явагчдын хөдөлгөөний урсгалыг илэрхийлнэ.

Нялхасын эндэгдэл: Тухайн жилийн 1000 амьд төрөлтөд ногдох 1 хүртлэх насандаа нас барсан нийт хүүхдийн тоогоор илэрхийлэгдэнэ.

Нас барах магадлал: Тодорхой насны хүн ам дараагийн насанд шилжихдээ нас барах магадлалаар илэрхийлэгдэнэ.

Шилжин амьдрах магадлал: Тодорхой насыг насалсан хүмүүсийн тоо байгалийн жам ёсоор жилээс жилд хорогдож, дараагийн насанд шилжсэнээр илэрхийлэгдэнэ.

ӨМНӨХ ҮГ



Улс орны бүхий л салбарын бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, богино, дунд болон урт хугацааны төлөвлөлт хийх үндсэн эх үүсвэрийн нэг нь хүн амын тоо, бүтцийн талаарх цогц мэдээлэл, тэр дундаа үндэслэлтэй боловсруулсан хүн амын хэтийн тооцоо юм.

Монгол Улсын Статистикийн байгууллага хүн амын хэтийн тооцоог 1963 оны тооллогоос хойш тооллого бүрийн дараа хийж, шинэчлэн баяжуулж ирсэн уламжлалтай бөгөөд энэ хугацаанд тооцооны аргыг улам боловсронгуй болгож, олон улсад хэрэглэдэг нийтлэг арга зүйг ашиглаж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнд суурилсан “Хүн амын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо” сэдэвчилсэн судалгаа нь улс, бүс, аймаг, нийслэлийн түвшний хэтийн тооцооны үр дүнг багтаасан цогц судалгаа юм. Сүүлчийн тооллогоор гадаадад удаан хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдээ анх удаа тоолсон учраас цаашид улс, орны бодлого, төлөвлөлтийг

оновчтой болгох зорилгоор тооцоонд ашигласан суурь хүн амыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам болон гадаадад оршин суугаа иргэдээ суурь хүн амдаа оруулсан Монгол Улсын хүн ам гэсэн 2 төрлөөр, хүн амын хэтийн тооцоог төрөлтийн аажим, дундаж, хурдацтай буурах түвшний 3, нийт 6 хувилбараар тооцооллоо. Тооцоог боловсруулахдаа хүн амын тооны өөрчлөлтөд нөлөөлөгч бүрэлдэхүүн болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний өнгөрсөн 10-20 жилийн хугацааны мэдээлэлд дүгнэлт өгч, цаашдын төлвийг бодит хандлагад тулгуурлан тодорхойлсон нь хэрэглэгчдэд ирээдүйн хүн амын тоо, өсөлт, нас, хүйсийн бүтэц, байршлын талаар төсөөлөл өгч, хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийг дахин авч үзэх бололцоог олгож байгаагаараа ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Нөгөө талаар бодлого боловсруулагч, судлаачдад хүн амын хөгжлийн бодлогын нөлөөллийг тусгасан хэтийн зорилтот тооцоо хийж, харьцуулах суурь эх үүсвэр болно гэдэгт итгэлтэй байна.

Сэдэвчилсэн судалгааны агуулга тооцооны үндсэн зарчим, арга зүй, тооцоонд ашиглах суурь хүн амын нас, хүйсийн бүтцийн шинжилгээ, хүн амын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн хэтийн таамаглал, хэтийн тооцооны үр дүн, дүгнэлт гэсэн 5 бүлгээс бүрдэх бөгөөд англи хэлэнд хөрвүүлэн хэвлүүлэхээс гадна цахим хэлбэрээр дэлгэрэнгүй мэдээллийг тархаасан болно.

Энэхүү сэдэвчилсэн судалгааг боловсруулж бэлтгэсэн ҮСХ-ны дэд дарга Б.Эрдэнэсүрэн, Шинжилгээ, судалгааны газрын дарга А.Амарбал, Хүн ам, орон сууцны тооллогын товчооны дарга Ж.Мөнхбаатар, зөвлөх Ц.Бадрах, шинжээч Т.Алтанцэцэг, Б.Уранбилэг, ажилтан Т.Жаргалсайхан, Ө.Эрдэнэчимэг болон аргачлал, арга зүйгээр хангасан олон улсын зөвлөх Рикардо Ньюперт болон үнэтэй санал зөвлөмжөө өгч, хамтарч ажилласан бүх хүнд талархлаа илэрхийлье.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

 С.МЭНДСАЙХАН

УДИРТГАЛ

Хүн амын хэтийн тооцоо нь статистикийн мэдээллийн нэг хэлбэр бөгөөд хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн болон хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц, байршлын талаарх ирээдүйн төлвийг урьдчилан таамагласан тооцоолол билээ. Тиймээс улс орны эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн бодлого боловсруулах, төлөвлөлт хийх, судалгаа, шинжилгээний зорилгоор хэтийн тооцоог боловсруулдаг.

Хүн амын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлсноор хүн амын нөхөн үйлдвэрлэлээс хамааралтай нийгмийн хэрэгцээ, түүнийг хангахад чиглэгдсэн эдийн засгийн нөөц боломжийг бүрдүүлэх, хөгжлийн бодлогыг харилцан уялдаатайгаар авч үзэх, хүний нөөцийн бүрдэлт, ашиглалт, ажиллах хүчний хэрэгцээ, хүн амын ундны болон бохир усны төвлөрсөн сүлжээ, боловсрол, нийгмийн халамж үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн хэмжээ, орон сууц, эмнэлэг, сургууль, зам, тээвэр, харилцаа холбоо зэрэг бүхий л салбарын ирээдүйн эрэлт, хэрэгцээг тооцож, бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Монгол Улсын статистикийн байгууллага хүн амын хэтийн тооцоог 1963 оны тооллогоос хойш тооллого бүрийн үр дүнд үндэслэн боловсруулсаар ирсэн уламжлалтай. Энэ удаагийн хүн амын хэтийн тооцоог Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 01/93 тоот тушаалаар батлагдсан “Хүн амын хэтийн тооцооны үзэл баримтлал”-ын дагуу ирээдүйн 30-н жилийн хугацааг хамруулан хийлээ. Ингэхдээ хүн амын бүрэлдэхүүн хэсэг болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний ирээдүйн чиг хандлагыг бодлогын нөлөөлөл хамгийн бага байхаар (төрөлт, нас баралтын таамаглалыг бодлогын нөлөөлөлгүйгээр боловсруулсан) буюу өнгөрсөн 20 жилийн хугацааны төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний мэдээлэлд дүгнэлт өгч, цаашдын төлвийг бодит хандлагад тулгуурлан тодорхойлов.


Улс, бүсийн түвшний хэтийн тооцоог бүрэлдэхүүний аргаар (cohort component method), аймгийн түвшний хэтийн тооцоог харьцааны аргуудын нэг болох үелрэл харьцаа болон дифференциал өсөлтийн аргаар (cohort relation and differential growth method) хийсэн нь хүн ам зүйн шинжлэх ухаанд тооцоолол боловсруулах сүүлийн үеийн арга техник ашигласнаараа онцлогтой байв.



Хүмүүнд төр эрхэм. Мөрд хүмүүн эрдэнэ

НЭГЛҮГЭЭР БҮЛЭГ

ХЭТИЙН ТООЦОНЫ АРГА ЗҮЙ



1.1. ХЭТИЙН ТООЦООНЫ АРГА ЗҮЙ

Монгол Улс хүн амын хэтийн тооцоог 1963 оноос хойших тооллого бүрийн дараа хийж, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд ашигласаар ирсэн туршлагатай. Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогын дүнд үндэслэн анх удаа төрөлт, нас баралтын түвшнээрээ ялгаатай үндсэн 3, дотроо гурав, нийт 9 хувилбараар хэтийн тооцоог боловсруулсан. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнд үндэслэсэн тооцоог төрөлтийн түвшнээрээ ялгаатай 3 хувилбараар хийсэн. Түүний дараа төрөлтийн 2000-2007 оны бодит түвшинд гарсан өөрчлөлт, нялхсын эндэгдлийн эрчимтэй бууралт, нөгөө талаас хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцрүүлэх үүднээс 2000 оны хүн амын тооллогын хүн амыг суурь болгосон тооцоог 2008 онд дахин шинэчилж боловсруулсан. Сүүлчийн 3 удаагийн тооцооны арга зүйг харьцуулан хүснэгт 1.1-т үзүүлэв.

Хүн амын хэтийн тооцооны үр дүнг улс орны нийгэм, эдийн засгийн ойрын болон хэтийн төлөвлөлт хийх, бодлого боловсруулах, судалгаа, шинжилгээнд суурь мэдээлэл болгон ашигладаг учир аль болох олон хувилбараар тооцдог. Энэ нь хүн ам зүйн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход олон хувилбараар таамаглал дэвшүүлэх шаардлагыг бий болгодог бөгөөд олон улсын нийтлэг жишгээс үзэхэд хамгийн багадаа 3 үндсэн хувилбараар таамаглалаа боловсруулдаг. Хувилбаруудын гол ялгаа нь хүн амын төрөлтийн түвшний өөрчлөлтөөс хамаарах явдал түгээмэл байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнд үндэслэсэн энэ удаагийн хэтийн тооцоог суурь хүн амын төрлөөр ангилсан 2 хувилбар, дотроо төрөлтийн түвшний чиг хандлагаараа ялгаатай 3 дэд хувилбараар боловсрууллаа. Үүнд:

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоонд үндэслэсэн тооцоо

1. Төрөлтийн аажим бууралттай "1А" хувилбар
2. Төрөлтийн дундаж бууралттай "1Б" хувилбар
3. Төрөлтийн хурдацтай бууралттай "1В" хувилбар

Монгол Улсын хүн амд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоог оруулсан тооцоо

4. Төрөлтийн аажим бууралттай "2А" хувилбар
5. Төрөлтийн дундаж бууралттай "2Б" хувилбар
6. Төрөлтийн хурдацтай бууралттай "2В" хувилбар орж байна.

Орчин үед хүн амын хэтийн тооцоог улс орнууд хийхдээ бүрэлдэхүүний аргыг ашиглаж байна. Энэ нь улс орныхоо хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний олон жилийн чиг хандлагад суурилан олон хувилбарт таамаглал дэвшүүлж, хүн амынхаа ирээдүйн тоо, өсөлт, нас, хүйсийн бүтцийг тодорхойлдог арга юм.

Хүн амын хэтийн тооцоог хийхдээ 3 түвшний тооцоог хийж гүйцэтгэсэн. Эхлээд улсын түвшинд үндсэн тооцоог, дараа нь бүсийн түвшний тооцоог хийж улсын дүнтэй нийцрүүлсэн бол бүсийн түвшний тооцоог аймгийн түвшинд задалж, бүсийн дүнтэй нийцрүүлэв. Түүнчлэн, улс, бүсийн түвшний тооцоог бүрэлдэхүүний арга (cohort component method)-аар, харин аймгийн түвшний тооцоог харьцааны аргын нэг болох үелрэл харьцаа болон дифференциал өсөлтийн арга (cohort relation and differential growth method)-аар, дээр дурдсан 6 хувилбараар тооцооллоо. Аймгийн түвшний тооцоонд ашигласан үелрэл харьцаа болон дифференциал өсөлтийн арга аймгуудын хүн амын сүүлчийн 2 тооллого хоорондын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлт, төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК), нэг наснаас нөгөө насанд шилжин амьдрах магадлалыг ашиглагдаараа бусад аргаас ихээхэн давуу талтай юм.

ХҮСНЭГТ 1.1.1 ХЭТИЙН ТООЦОНЫ АРГА ЗҮЙН ХАРЬЦУУЛАЛТ

Тооцооны үндсэн арга зүй, таамаглал	Хүн амын хэтийн тооцоо, 2002 он	Хүн амын хэтийн тооцоо, 2008 он	Хүн амын хэтийн тооцоо, 2010 он
Арга зүй	Бүрэлдэхүүний арга	Бүрэлдэхүүний арга	Улс, бүсийн түвшний хэтийн тооцоог бүрэлдэхүүний аргаар (cohort component method), аймгийн түвшний хэтийн тооцоог үелрэл харьцаа болон дифференциал өсөлтийн аргаар (cohort relation and differential growth method) хийсэн.
Суурь хүн амын нас, хүйсийн шинжилгээ	Улсын түвшинд хийсэн	Улсын түвшинд хийсэн	Улс, аймаг, нийслэлийн түвшинд хийсэн
Тооцооны хувилбар	3 хувилбар	6 хувилбар	6 хувилбар
Таамаглал			
Төрөлт	Төрөлтийн огцом бууралттай төсөөллийг дэвшүүлсэн бөгөөд дээд, дунд, доод гэсэн 3 хувилбарыг боловсруулсан.	Төрөлтийн аажим бууралттай төсөөлөл дэвшүүлсэн бөгөөд дээд, дунд, доод гэсэн 3 хувилбарыг боловсруулсан.	2002, 2008 оны тооцоотой харьцуулахад төрөлтийн илүү аажим бууралттай төсөөлөл дэвшүүлсэн бөгөөд дээд, дунд, доод гэсэн 3 хувилбарыг боловсруулсан.
Нас баралт	Нас баралтын хувьд нэг таамаглал дэвшүүлсэн.	Нас баралтын аажим болон хурдтай бууралттай гэсэн 2 төсөөлөл дэвшүүлсэн.	Нас баралтын хувьд нэг таамаглал дэвшүүлсэн.
Дундаж наслалт	Насжилтын хүснэгтийн загвар Коал Демений Баруун загвартай ойролцоо гарсан.	Mortpak ашиглан тооцсон 2003 оны ХАНҮЭМС-ны нялхас, хүүхдийн нас баралт НҮБ-ын Far East Asia загвартай ойролцоо гарсан.	Mortpak ашиглан тооцсон насжилтын хүснэгтийн загвар НҮБ-ын Far East Asia загвартай ойролцоо гарсан.
Гадаад шилжих хөдөлгөөн	Бүх гадаад цэвэр шилжилтийг Улаанбаатараас гарна гэж үзсэн бөгөөд нийт цэвэр шилжилт 2000-2005 онд -15000 байна гэж таамагласан.	Цэвэр шилжих хөдөлгөөний таамаглалыг дунд болон богино хугацаанд цэвэр шилжилт нь тэгээс ялгаатай боловч аажим буурсаар 2022-2030 онд тэг болно гэж таамагласан. Өөрөөр хэлбэл, цэвэр шилжих хөдөлгөөнийг илүү хурдтай буурахаар авч үзсэн.	Гадаад шилжих хөдөлгөөний чиг хандлага цаашид аажмаар буурч, цэвэр шилжих хөдөлгөөн эерэг байхаар төсөөлөв. Ингэхдээ гадаад руу шилжин явсан иргэд буцаж аймаг, нийслэлдээ ирнэ гэж үзсэн.
Дотоод шилжих хөдөлгөөн	Дотоод шилжих хөдөлгөөний хандлага цаашид буурч, 2025 онд тэг болохоор таамагласан.		Дотоод шилжих хөдөлгөөний хандлагыг цаашид буурч, 2040 он гэхэд 30 хүртэл хувиар буурна гэж үзсэн.
Боловсруулалт	Тооцооллыг People програм хангамжаар хийж гүйцэтгэсэн.	Тооцооллыг MORTPAK 4.0 болон PDE Population Module программ хангамжуудаар хийж гүйцэтгэсэн.	Тооцооллыг улс, бүсийн түвшинд RUP (Rural urban projection) програм хангамж, аймгийн түвшинд Cohort relation and differential growth method аргыг ашиглан excel програмаар хийв.
Үр дүн	Улсын дүнгээр 1 насаар, аймаг, нийслэлээр 5 насны бүлэг, 5 жилийн интервалтайгаар, хүйсээр тооцоолсон.	Улсын дүнгээр, нэг нас, хүйсээр тооцоолсон.	Улс, аймаг, нийслэл, бүсээр 1 нас, хүйс, 5 жилийн интервалтайгаар тооцсоноороо илүү нарийвчлалтай.

Бүрэлдэхүүний аргаар тооцоог хийхдээ АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан RUP (Rural Urban Projection) програмыг, харьцааны аргаар аймгийн хүн амын тооцоог гаргахдаа Cohort relation and differential growth програмыг ашиглав.

ХҮСНЭГТ 1.1.2. ХЭТИЙН ТООЦОО ХИЙХЭД АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ПРОГРАМУУД

Үндсэн мэдээлэл	Програмд ашиглагдах үзүүлэлтүүд	RUP (Rural Urban Projection)	Cohort relations and differential Growth
Хүн амын тоо	Хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2010 он	+	+
Төрөлт	Төрөлтийн нийлбэр коэффициент, 2010-2040 он	+	+
	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2010-2015 он	+	+
Нас баралт	Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр, 2010 он	+	-
	Шилжин амьдрах магадлал, насны бүлэг, хүйсээр, 2045 он	+	+
	Дундаж наслалт, хүйсээр, 2010-2040 он	+	-
Дотоод шилжих хөдөлгөөн	Дотоод цэвэр шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо: - Насны бүлэг, хүйсээр, 2010-2015 он - Хүйсээр, 2010-2040 он	+	-
Гадаад шилжих хөдөлгөөн	Гадаад цэвэр шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо: - Насны бүлэг, хүйсээр, 2010-2015 он - Хүйсээр, 2010-2040 он	+	-

Бүсийн түвшний тооцоог бүрэлдэхүүний аргаар хийхдээ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан эдийн засгийн бүсэд хамаарах аймгуудын хуваариас ялгаатайгаар аймгуудыг бүлэглэв. Ингэхдээ аймаг, нийслэлийн хүн амын төрөлтийн ойролцоо түвшинг харгалзан зөвхөн тооцооны зорилгоор “бүлэг” болгож, бүлэг тус бүрт төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний таамаглалыг дэвшүүлж, тооцоог хийв. Энэ нь аймаг, нийслэлийн хүн амын тооны нийлбэр нь улсын дүнтэй тохирох гол нөхцлийг бүрэлдүүлж байв.

ХҮСНЭГТ 1.1.3. ТӨРӨЛТИЙН ОЙРОЛЦОО ТҮВШНЭЭР ТООЦСОН ТНК, БҮЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Бүлэг	Аймаг, нийслэл	2001-2005 оны дундаж ТНК	2005-2010 оны дундаж ТНК	2001-2010 оны дундаж ТНК
5-р бүлэг	Улаанбаатар	1.63	2.20	2.00
1-р бүлэг	Дархан-Уул	1.76	2.25	2.05
	Орхон	1.81	2.23	2.07
	Дорнод	1.96	2.25	2.15
	Булган	2.01	2.24	2.16
	Дундговь	2.10	2.28	2.22
2-р бүлэг	Төв	2.10	2.27	2.23
	Говь-Алтай	2.12	2.30	2.24
	Завхан	2.08	2.37	2.27
	Дорноговь	2.13	2.36	2.28
	Говьсүмбэр	2.00	2.42	2.28
	Өмнөговь	2.23	2.28	2.30
	Баянхонгор	2.31	2.26	2.30
	Хөвсгөл	2.19	2.41	2.33
	Сүхбаатар	2.51	2.23	2.39
	3-р бүлэг	Сэлэнгэ	2.32	2.42
3-р бүлэг	Өвөрхангай	2.38	2.46	2.44
	Архангай	2.42	2.50	2.50
	Хэнтий	2.49	2.59	2.59
4-р бүлэг	Ховд	2.62	2.72	2.70
	Увс	3.14	3.42	3.33
	Баян-Өлгий	3.73	3.31	3.52
	Бүгд	2.06	2.33	2.26

ХҮН АМЫН ХЭТИЙН ТООЦООГ БОЛОВСРУУЛСАН ҮЕ, ШАТ


1. Улс, аймаг, нийслэлийн 2010 оны тооллогын дүнгээрх хүн амын нас, хүйсийн бүтцэд дүн шинжилгээ хийж, суурь оны хүн амын тоог бэлтгэх;
2. Төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний сүүлчийн 20 орчим жилийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэтийн төлвийн таамаглал дэвшүүлэх;
3. Бүс, аймаг, нийслэлээр хүн амын хэтийн тооцоог 6 хувилбараар боловсруулах;
4. Хэтийн тооцооны үр дүнг нэгтгэн боловсруулах;



Хүмүүнд төр эрхэм. Мөрд хүмүүн эрдэнэ

ХОЁРЛУГААР БҮЛЭГ

ХЭТИЙН ТООЦООНЫ СУУРЬ ХҮН АМЫН
МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ



2.1. СУУРЬ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ҮНЭЛГЭЭ


Хүн амын тооллогын дүнгээрх нас, хүйсээр ангилсан мэдээлэл нь тухайн улс орны уламжлалт ёс заншил, шашин шүтлэг зэргээс хамаарч, төрсөн он, сар, өдрөөр эхлэн тоолсон наснаас зөрүүтэй гарах явдал байдаг. Тухайлбал, Монголын ард түмний уламжлалт аргаар насыг эхийн хэвлийд бүрэлдсэнээс хойш тоолох гэх мэт. Улс орнууд янз бүрээр тодорхой тоог эрхэмлэх явдал багагүй байдаг аж. Өөрөөр хэлбэл, тооллогын онд тухайн хүний насны сүүлчийн орон тэг эсвэл тавтай ойрхон тоогоор төгссөн нөхцөлд насныхаа сүүлчийн оронг тэг буюу тавруу шилжүүлэн хэлэх (Нас эрхэмлэх) тохиолдол нэлээд байдаг. Гэхдээ нас эрхэмлэлт нь ямар хэмжээтэй байхаас хамаарч нас, хүйсийн бүтцийг залруулах эсэхийг шийддэг олон аргууд бий. Хэрэв нас, хүйсийн мэдээлэл тогтсон хэмжээнээс илүү алдаатай нөхцөлд уг алдааг хэтийн тооцоо болон бусад судалгаа шинжилгээнд залруулан ашиглах нь хүн амын нас, хүйсийн бодит хандлагыг шинжлэн судлахад чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндэсний статистикийн байгууллага хүн амын тооллогын нас, хүйсийн мэдээлэл хэр зэрэг алдаатай эсэхийг шалган тогтоосоор ирсэн билээ. Үүнээс орчин үед олон улсад түгээмэл хэрэглэгдэж байгаа Випплийн индекс (Whipple index), Мэрийн холимог индекс (Myer's blended index) болон Нэгдсэн Үндэстний байгууллагын нас, хүйсийн индекс (United Nation's Age, Sex Accuracy Index)-ийг сонгон судалгаандаа ашиглав.

2.1.1. НҮБ-ЫН НАС, ХҮЙСИЙН ИНДЕКС (UNITED NATION'S AGE, SEX ACCURACY INDEX)

НҮБ-ын нас, хүйсийн индекс нас, хүйсийн мэдээллийн чанарыг хамтад нь шинжилдгээрээ давуу талтай. Уг индексээр тооцсон үзүүлэлт 20-оос бага бол алдаагүй, 20-иос 40-ийн хооронд бол алдаатай, 40-өөс их бол их алдаатай гэж үздэг.

ЗУРАГ 2.1.1. НҮБ-ЫН НАС, ХҮЙСИЙН ИНДЕКС, 1963-2010 ОН



Тооцооноос үзэхэд улсын түвшинд манай улсын хүн амын 1963-2010 оны тооллогын дүнгээрх нас, хүйсийн мэдээлэл нь зохих хэмжээний алдаатай ч уг алдаа тогтвортой буурчээ. Тиймээс судалгаа, тооцоонд хүн амын нас, хүйсийн мэдээллийг засварлан ашиглах шаардлагатай гэсэн ерөнхий дүгнэлтийг хийж болно. Гэхдээ 2010 оны тооллогын дүнгээрх улсын түвшний нас, хүйсийн мэдээллийг засварлахгүйгээр тооцоонд ашиглахаар шийдвэрлэсэн. Учир нь 2005 оноос хойш төрөлт нэмэгдэж байгаа нь уг индексийн утга өндөр гарахад нөлөөлсөн юм.


Хэдийгээр улсын түвшинд мэдээллийг засварлахгүй боловч энэ индекс аймгуудад ихээхэн ялгаатай (31.3-75.6), тэр дундаа Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Булган, Сүхбаатар, Хэнтий аймгуудад 40-өөс дээш гарсан нь аймаг, нийслэлийн нас, хүйсийн бүтцэд тодорхой алдаа байгааг харуулж байна (хүснэгт 2.1.1).

Дээрх аргаар нас, хүйсийн мэдээллийн алдаатай эсэхийг хамтад нь шинжилж байсан бол дараах аргаар зөвхөн нас эрхэмлэлт хэр зэрэг байгааг дангаар нь судалдаг.

2.1.2. ВИППЛИЙН ИНДЕКС (WHIPPLE INDEX)

Хүн амын тооллогын асуулгад хувь хүн насаа хэлэхдээ тодорхой тоог эрхэмлэдэг явдал багагүй байдгийг дээр тэмдэглэсэн. Випплийн индекс нь хүний насны сүүлчийн орон тэг эсвэл 5-аар төгссөн тоонд ойрхон байсан нөхцөлд тооллогоор насаа уг тоонд шилжүүлсэн эсэхийг (Нас эрхэмлэх хандлага) тодорхойлдог. Энэ индексийн тооцоогоор үр дүн нь 100-тай ойр бол нас эрхэмлэлт байхгүй гэж үздэг.

ЗУРАГ 2.1.2. ВИППЛИЙН ИНДЕКС, 1963-2010 ОН




Випплийн индекс 2010 оны тооллогын дүнгээр 102, аймгуудын хувьд ялгаа бага, 100-аас 0.5-4.1-ийн хэлбэлзэлтэй гарсан нь нас эрхэмлэлтийн алдаа бараг байхгүй болохыг харуулав (хүснэгт 2.1.1).

2.1.3. МЭЕРИЙН ХОЛИМОГ ИНДЕКС (MYER'S BLENDED INDEX)

Мэерийн холимог индекс (МХИ) нь нас эрхэмлэх хандлага 0-9 цифрээр төгссөн насанд ажиглагдаж байгаа эсэхийг шинжилдгээрээ Випплийн индексээс давуу талтай юм.

ЗУРАГ 2.1.3. МЭЕРИЙН ХОЛИМОГ ИНДЕКС, 1963-2010 ОН



Мэерийн холимог индексийн үр дүн тэгээс хэр зэрэг зөрүүтэй байгаагаас хамаарч, нас эрхэмлэлт 10-аас дээш насанд байгаа эсэхийг тогтоодог. Уг индексийн тооцооны үр дүн тэг рүү ойртох тутам тодорхой тоог эрхэмлэх хандлага байхгүйг илэрхийлдэг. Монгол Улсын хүн амын тооллогуудын (10-аас дээш насны хүн амын нас, хүйсийн мэдээлэлд) Мэерийн холимог индексийн аргаар хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд улсын түвшинд 1963 оны тооллогоор 2.4 байснаа 1979 онд 2.7 болж нэмэгдэн түүнээс хойших тооллогуудад буурсаар 2010 онд 0.9 гарсан нь 10-аас дээш насанд тодорхой тоог эрхэмлэх хандлага буурч байгааг харууллаа. Харин 2010 оны тооллогоор аймаг, нийслэл бүрт Мэерийн индекс тооцоход 1.03-2.53 хооронд гарч, аймгийн түвшинд алдаа байгааг харуулав (хүснэгт 2.1.1).

ХҮСНЭГТ 2.1.1. СУУРЬ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ИНДЕКСИЙН
ШИНЖИЛГЭЭ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Мэрийн холимог индекс	НҮБ-ын хүн амын нас, хүйсийн индекс	Випплийн индекс
Улсын дүн	0.86	26.06	101.62
Архангай	1.28	32.65	101.66
Баян-Өлгий	1.94	31.29	101.94
Баянхонгор	1.69	39.38	100.63
Булган	1.88	44.17	102.57
Говь-Алтай	1.69	37.58	103.02
Говьсүмбэр	2.14	53.84	101.67
Дархан-Уул	1.58	33.42	101.68
Дорноговь	1.33	42.34	101.45
Дорнод	1.44	38.50	101.65
Дундговь	1.76	50.84	100.49
Завхан	1.45	39.84	101.58
Орхон	1.03	39.35	103.24
Өвөрхангай	1.72	31.51	102.28
Өмнөговь	2.32	75.57	101.81
Сүхбаатар	1.53	44.11	98.58
Сэлэнгэ	1.80	39.49	104.07
Төв	1.39	34.64	101.56
Увс	1.68	31.98	100.66
Улаанбаатар	2.53	34.59	101.44
Ховд	2.43	37.40	96.90
Хөвсгөл	2.13	32.65	103.05
Хэнтий	1.74	40.61	103.77

Дээрх индексийн аргаар хийсэн улсын түвшний шинжилгээний дүнгээс харахад тооллогоос тооллогод улсын хүн амын нас, хүйсийн мэдээллийн чанар мэдэгдэхүйц сайжирсан хэдий ч аймаг, нийслэлийн түвшинд ялгаатай байлаа. Аймаг, нийслэлийн хүн амын 2010 оны тооллогын дүнд суурилсан индексийн шинжилгээг харахад нас, хүйсийн бүтцийг шулуутгаж, хэтийн тооцоонд ашиглах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Тиймээс аймаг, нийслэлийн хүн амын нас, хүйсийн бүтцийг НҮБ-ын зөөлөн шулуутгалын аргаар шулуутгаж, тухайн түвшний тооцоонд ашиглав.

2.2. ХҮН АМ НЭГ НАСНААС НӨГӨӨ НАСАНД ШИЛЖИН АМЬДРАХ МАГАДЛАЛЫН (РХ) ШИНЖИЛГЭЭ

Улсын хэмжээгээр үзвэл тодорхой насыг насалсан хүмүүсийн тоо байгалийн жам ёсоор (шилжих хөдөлгөөний нөлөөлөл байхгүй гэж тооцвол) жилээс жилд хорогдож дараагийн насанд шилжиж байх учиртай. Тухайлбал, 2009 онд 20 настай байсан хүмүүсийн тоо 21 насанд шилжихдээ тодорхой тоогоор буурч, дийлэнх хэсэг нь 21 насанд шилжинэ гэсэн ойлголт юм. Эдгээр үзүүлэлтийг хүн ам зүйн шинжлэх ухаанд цогцоор нь насжилтын хүснэгтээр тооцож тодорхойлдог. Насжилтын хүснэгтэд дараа насанд шилжин амьдрах магадлалыг (Рх) гэж тэмдэглэдэг.

Тооллогын мэдээллийн чанарыг шалгах дараагийн арга бол хүн амын дараа насанд шилжин амьдрах магадлалын шинжилгээ (intercensal cohort analysis) юм.

2.2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ДАРАА НАСАНД ШИЛЖИН АМЬДРАХ МАГАДЛАЛ (РХ)- ҮН ШИНЖИЛГЭЭ

Шинжилгээг хийхдээ 10, түүнээс дээш насны хүн амыг хамруулдаг бөгөөд тооцооны арга нь энгийн зарчимд тулгуурладаг. Энэ нь 2 тооллогын хүн амын тооны зөрүүнд үндэслэсэн шилжин амьдрах магадлалыг тооллого хоорондын хугацаанд бүртгэгдсэн нас баралтын мэдээллээс тооцсон шилжин амьдрах магадлалтай харьцуулж үнэлэх арга юм. Өөрөөр хэлбэл, 2000 оны тооллогод хамрагдсан 1 настай хүүхэд 2010 онд 10 настай байх ба 10 жилийн дараа тэдний хэд нь амьд байгаагаар харьцуулан тооцсон магадлалыг 2000-2010 оны хооронд бүртгэгдсэн нас баралтаар тооцсон насжилтын хүснэгтийн холбогдох үзүүлэлттэй зэрэгцүүлж тооцно гэсэн үг юм.

Хүснэгт 2.2.1-ээс харахад тооллого хоорондын хүн амын тоог харьцуулан тооцсон магадлал (багана 3, 4), нас баралтын сүүлчийн 10 жилийн дунджаар тооцсон насжилтийн хүснэгтийн магадлал (багана 5, 6-р) баганын дүнтэй харгалзан аль болох бага зөрүүтэй байх тутам тооллогын мэдээллийн чанар сайн байгааг харуулна.

ХҮСНЭГТ 2.2.1. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТООЛЛОГО ХООРОНДЫН БОЛОН ДАРАА НАСАНД ШИЛЖИН АМЬДРАХ МАГАДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ, 2010 ОН

Нас		Шилжин амьдрах магадлал				Зөрүү /хувиар/		Хүйсийн харьцаа	
		Тооллого хоорондын хүн амын тооны хувьд тооцсон		Хүн амын 2000-2010 оны нас баралтаар тооцсон насжилтийн хүснэгт		Эрэгтэй	Эмэгтэй	Тооллого	Насжилтын хүснэгт
2000	2010	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй				
-	0-4	-	-	-	-	-	-	-	-
-	5-9	-	-	-	-	-	-	-	-
0-4	10-14	0.9645	0.9610	0.9897	0.9939	-2.5	-3.3	1	1
5-9	15-19	0.9047	0.8991	0.9925	0.9965	-8.8	-9.8	1.01	1
10-14	20-24	0.9258	0.9151	0.9892	0.9949	-6.4	-8	1.01	0.99
15-19	25-29	0.9337	0.9497	0.9847	0.9924	-5.2	-4.3	0.98	0.99
20-24	30-34	0.9488	0.9390	0.9813	0.9899	-3.3	-5.1	1.01	0.99
25-29	35-39	0.9338	0.9344	0.9766	0.9864	-4.4	-5.3	1	0.99
30-34	40-44	0.9546	0.9538	0.9669	0.9807	-1.3	-2.7	1	0.99
35-39	45-49	0.9131	0.9262	0.9496	0.9710	-3.8	-4.6	0.99	0.98
40-44	50-54	0.9264	0.9918	0.9206	0.9552	0.6	3.8	0.93	0.96
45-49	55-59	0.8230	0.9121	0.8758	0.9309	-6	-2	0.9	0.94
50-54	60-64	0.7978	0.9077	0.8098	0.8946	-1.5	1.5	0.88	0.91
55-59	65-69	0.6305	0.7354	0.7155	0.8403	-11.9	-12.5	0.86	0.85
60-64	70-74	0.6296	0.7554	0.6010	0.7618	4.8	-0.8	0.83	0.79
65-69	75-79	0.4538	0.5848	0.4768	0.6600	-4.8	-11.4	0.78	0.72
70-74	80-84	0.3717	0.5149	0.3493	0.5252	6.4	-2	0.72	0.67
75-79	85-89	0.2363	0.3370	0.3262	0.5485	-27.6	-38.6	0.7	0.59
80-84	90-94	0.1644	0.2286	-	-	-	-	-	-
85-89	95-99	0.0807	0.1350	-	-	-	-	-	-
90-94	100+	0.0414	0.0897	-	-	-	-	-	-

2.2.2. АРАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮН АМЫН ШИНЖИЛГЭЭ

Хүн амын тооллогоор 10 хүртэлх насны хүүхдийн тоо хэр зэрэг хамралттай байгааг тусгай аргаар тооцдог. Захиргааны статистикийн мэдээллээр нялхсын эндэгдэл бүрэн бүртгэгдсэн эсэх нь зарим талаар эргэлзээтэй байдаг. Мөн насаа буруу хэлэх зэргээс үүдэн, хүүхдийн тооны талаарх мэдээллийн чанарыг судлах нь хэтийн тооцоо хийхэд чухал ач холбогдолтой юм.

Тооцооноос үзэхэд 2010 оны тооллогоорх Монгол Улсын 10 хүртэлх насны хүүхдийн тоог, 2000-2010 онд төрсөн хүүхдийн тоог (ердийн хөдөлгөөний статистикийн мэдээллээр гарсан) насжилтийн хүснэгтийн дараа насанд шилжих амьдрах магадлал (Px)-аар тооцож, дүнг тооллогын холбогдох насны бүлгийн хүн амын тоотой харьцуулбал, тооцоолсон насны бүлэг тус бүрд тооллогын тоо ердийн хөдөлгөөний мэдээний тоог үндэслэн тооцсон тооноос илүү байгаа нь тооллогын мэдээллийн чанар сайн байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2.2.2. ТООЛЛОГО, ЗАХИРГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ ХООРОНДЫН 10-ААС ДООШ НАСНЫ ХҮН АМЫН ТООНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ, 2010 ОН

Төрсөн жил	Төрсөн хүүхдийн тоо	Төрсөн хүүхдийн тоо /засварласан /		Шилжин амьдрах магадлал	Тооцооны хүн ам	Тооллогын хүн ам		Зөрүү /Дотоодын ХА/		Зөрүү /Нийт ХА/	2010 оны нас	
		/12.25-1.10/	/1.10-12.25/			/Дотоодын/	/Нийт/	Тоогоор	Хувиар			Тоогоор
Эрэгтэй												
2010	32 299	27 786	32 678	0.9713	31 741	32 202	32 468	461	1.5	727	2.29	<1
2006-2009	35 015	30 122	119 668	0.9935	118 887	114 314	116 357	-4573	-3.8	-2530	-2.13	1-4
2009	32 527	27 982	34 667									
2008	32 527	27 982	4 545									
2007	28 750	24 733	4 017									
2006	25 055	21 554	3 501									
2001-2005			118 843	0.9621	114 335	110 117	111 707	4218	3.7	2628	2.3	5-9
2005	23 002	19 788	3 214									
2004	23 219	19 975	3 244									
2003	23 092	19 865	3 227									
2002	24 112	20 743	3 369									
2001	25 162	21 646	3 516									
2000	24 832	21 362	3 470									
Эмэгтэй												
2010	30 971	26 644	31 415	0.9765	30 677	31 340	31 580	663	2.2	903	2.94	<1
2006-2009	34 152	29 380	115 663	0.9945	115 027	110 641	112 690	-4386	-3.8	-2337	-2.03	1-4
2009	31 241	26 876	33 745									
2008	31 241	26 876	4 365									
2007	27 886	23 990	3 896									
2006	24 037	20 678	3 359									
2001-2005			114 789	0.9691	111 242	106 097	107 672	-5145	-4.6	-3570	-3.21	5-9
2005	22 324	19 205	22 318									
2004	22 282	19 169	22 331									
2003	22 631	19 469	22 656									
2002	22 810	19 623	23 049									
2001	24 523	21 096	24 434									
2000	23 889	20 551	3 338									

Эх үүсвэр: Хүн амын ердийн хөдөлгөөний мэдээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХЭТИЙН ТООЦООНЫ ТӨСӨӨЛӨЛ, ТААМАГЛАЛ



Хүн амын 2010-2040 оны хэтийн тооцооны таамаглалыг Үндэсний статистикийн хороо, НҮБ-ийн ХАС-ийн зөвлөлтэй хамтран боловсруулж, холбогдох яам, эрдэм шинжилгээний байгууллагуудад танилцуулан саналыг авч, ярилцаж ойлголцсон.

Дэлхийн улс орнуудын хэтийн тооцоо боловсруулж байгаа аргачлалаас үзэхэд төрөлтийн түвшингээрээ ялгаатай олон хувилбараар, нас баралт, шилжих хөдөлгөөний нэг хувилбараар төсөөлөл, таамаглалаа дэвшүүлэх явдал түгээмэл байна. Энэ нь ихэнх оронд нас баралтын түвшин харьцангуй тогтворжиж, хүн амын тооны өөрчлөлтөд төрөлт голлох нөлөө үзүүлэх болсонтой холбоотой. Шилжих хөдөлгөөний хувьд гол хүчин зүйлийн нэг мөн хэдий ч таамаглал дэвшүүлэхэд хамгийн хүндрэлтэй бөгөөд бодлогын болоод нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай, богино хугацаанд үр дүн нь илэрдэг бүрэлдэхүүн юм. Тиймээс тухайн улс орны төрөлтийн түвшин хэр зэрэг өөрчлөгдөхийг бодитой таамаглахаас хүн амын хэтийн тооцооны чанар хамаарна. Таамаглалыг дэвшүүлэхдээ Монгол Улсын төрөлтийн өнгөрсөн 10-20 жилийн өмнөх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох хувилбаруудыг боловсруулсан.

Хүн амын 2010-2040 он хүртэлх хугацааны төрөлтийн таамаглалыг үндсэн 3 хувилбараар боловсруулав. Үүнд:

- Төрөлт аажим буурах
- Төрөлтийн бууралт дундаж хурдацтай буурах
- Төрөлт хурдацтай буурах гэсэн хувилбаруудыг авч үзлээ.

Харин хүн амын нас баралтын түвшинг нялхсын эндэгдэл болон насны бүлэг дэх нас баралтын коэффициентэд үндэслэн нэг хувилбараар, гадаад цэвэр шилжих хөдөлгөөний таамаглалыг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоонд үндэслэсэн тооцоонд мөн нэг хувилбараар боловсруулж ашиглав. Түүнчлэн, Монгол Улсын хүн амд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоог оруулсан тооцоо (2А, 2Б, 2В хувилбар)-нд гадаад шилжих хөдөлгөөнийг “0” буюу “тэг” гэж авч үзсэн бөгөөд бүс, аймаг, нийслэлийн түвшинд дотоод цэвэр шилжих хөдөлгөөний төсөөллийг боловсруулж, бүх хувилбарын тооцоонд хэрэглэсэн болно.

3.1. ТӨРӨЛТИЙН ТААМАГЛАЛ


УЛСЫН ТҮВШНИЙ ТӨРӨЛТИЙН ТААМАГЛАЛ

Монгол Улсын хүн амын төрөлтийн түвшин 1990-2000 онд тогтвортой буурсан боловч сүүлчийн 10 жилд нэлээд хэлбэлзэлтэй байсан нь төрөлтийн таамаглал дэвшүүлэхэд хүндрэлтэй байв. Төрөлтийн таамаглалыг төрөлтийн нийлбэр коэффициент (төрөх насны нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо)-оор тооцов. Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) 1990 онд 4.47 байснаа 1995 онд 2.76, 2000 онд 2.24 болж, 1990 оны түвшнээс хоёр дахин буурсан. Хүн ам зүйд ТНК хамгийн багадаа 2.1 байвал хүн амын нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшин хадгалагдана гэж үздэг. Харин 2003 онд ТНК нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс бага 2.02 болж, 2005 онд 1.95 болтлоо буурсан нь Монгол Улсын түүхэн дэх хамгийн бага үзүүлэлт байлаа.

Төр, засгаас төрөлтийг дэмжих арга хэмжээ авсан нь тодорхой хэмжээгээр нөлөөлж, 2007-2009 онд ТНК 2.36-2.69 болж өссөн боловч 2010 онд буурч 2.39 болов. ТНК-ийн 2000-2005 оны дунжийг авч үзвэл нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшинд байснаа сүүлчийн 5 жилийн дунджаар 2.33 болж өсчээ.

Улсын Их Хурлаас 2004 онд баталсан Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод “Гэр бүлийн хос 3, түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөхийг урамшуулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх чиглэл баримтална” гэсэн заалт болон бусад зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2011 оноос эхлэн олон хүүхэд төрүүлсэн эхчүүдэд олгодог эхийн алдар I, II зэргийн одонг олгох журмыг өөрчлөн, нэг эхийн төрүүлж өсгөсөн хүүхдийн тоог бууруулахын зэрэгцээгээр тодорхой хэмжээний мөнгөн урамшуулал олгодог болсон зэрэг төр засгаас хүн амын төрөлтийг дэмжих арга хэмжээний дүнд цаашид төрөлтийн нийлбэр коэффициент хүн амын эргэн нөхөгдөх түвшний орчимд байх магадлал байгаа юм. Иймээс төрөлтийн аажим бууралттай болон дунд зэргийн бууралттай байхад 2040 он хүртэл төрөлтийн нийлбэр коэффициент эргэн нөхөгдөх түвшинд байхаар таамаглалаа.

ЗУРАГ 3.1.1. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН




Манай улсын хүн амын насны бүлэг дэх төрөлтийн коэффициент хамгийн өндөр байдаг 20-29 насны эмэгтэйчүүдийн тоо 2015 оноос эхлэн буурах хандлагатай байна (Зураг 3.1.1). Тиймээс 2000-2005 оны төрөлт хамгийн бага түвшинд буурсан үеийн охид, 2020 оноос эхлэн нөхөн үржихүйн насанд шилжиж байгааг харгалзан, хүн амын төрөлт 2010-2015 онд нэмэгдэж, 2016 оноос буурч эхэлнэ гэж төрөлтийн таамаглалыг дэвшүүллээ. Үүнд:

1. Төрөлтийн хэмжээ аажим буурах түвшний таамаглалд төрөлтийн нийлбэр коэффициент 2015 он хүртэл бага зэрэг өсч, түүнээс хойш аажим буурсаар 2040 онд 2.49 байх;
2. Төрөлтийн хэмжээ дундаж хурдтай буурах түвшний таамаглалд төрөлтийн нийлбэр коэффициент 2015 он хүртэл бага зэрэг нэмэгдэж, 2015 оноос хойш тогтвортой буурсаар 2040 онд 2.19 байх;
3. Төрөлтийн хэмжээ хурдацтай буурах түвшний таамаглалд төрөлтийн нийлбэр коэффициент 2015 оноос хурдацтай буурсаар 2040 онд 1.89 байх хувилбаруудыг авч үзэв.


Дээрх хувилбарыг нэгтгэн дараах зурагт үзүүлэв.

ЗУРАГ 3.1.2. ТААМАГЛАСАН ТӨРӨЛТИЙН НИЙЛБЭР КОЭФФИЦИЕНТ, ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН



Хүүхэд төрүүлэх насны эмэгтэйчүүдийн насны бүлэг дэх төрөлтийн коэффициентийн 2005-2010 оны чиг хандлагаас үзэхэд хүүхэд төрүүлэх хамгийн идэвхтэй үе 20 наснаас эхэлж өссөөр, оргил үе нь 25-29 насанд байж, цаашид жигдхэн буурсаар 40-44 насанд хамгийн доод түвшинд очиж байна. Энэ нь Азийн улс орнуудад ажиглагдаж байгаа эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх насны нийтлэг чиг хандлага бөгөөд ирээдүйн насны бүлэг дэх төрөлтийн коэффициентийг Азийн загвараар тодорхойлогдоно гэж үзэх үндэслэлтэй юм. Тиймээс дэвшүүлж байгаа таамаглалаас үзэхэд эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх хамгийн идэвхтэй болон оргил үе нь өмнөх 2005-2010 оны түвшинд хадгалагдаж байгаа боловч 25-29 наснаас 35-39 нас хүртэл нэлээд огцом буурах хандлага ажиглагдаж байна (Зураг 3.1.3).

ЗУРАГ 3.1.3. НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ТӨРӨЛТИЙН КОЭФФИЦИЕНТ, ХУВИЛБАРААР, 2005-2010, 2040 ОН



Гэхдээ төрөлтийн түвшин аажим, дундаж хурдаар буурах хувилбарт 25-29 насны эмэгтэйчүүдийн төрөлт нийт төрөлтийн 37 хувь болж, 30 жилийн өмнөхөөсөө 6 пунктээр өсөх хандлага ажиглагдаж байна. Тиймээс улс орны хөгжлийн хурд, эмэгтэйчүүдийн боловсрол, ажил эрхлэлт нэмэгдэхийн хэрээр нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо цөөрч, богино хугацаанд хүссэн тооны хүүхдээ төрүүлэх сонирхол нэмэгддэг ерөнхий хандлага манайд ч байх төлөвтэй.

БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТҮВШНИЙ ТӨРӨЛТИЙН ТААМАГЛАЛ

Аймаг, нийслэлийн төрөлтийн нийлбэр коэффициентийн ойролцоо түвшнээр бүлэглэсэн бүлэг тус бүрийн сүүлчийн 5 жилийн дундаж ТНК-д тулгуурлан, цаашдын хандлагыг улсын түвшний ТНК-ийн өөрчлөлттэй ижил байхаар тус түвшний таамаглалыг дэвшүүлэв. Төрөлтийн дундаж бууралттай таамаглалаар 2010-аас 2040 он хүртэл бүлэг тус бүрийн ТНК 0.26-0.36 пунктээр буурахаар байна.


ХҮСНЭГТ 3.1.1. ТААМАГЛАСАН ТӨРӨЛТИЙН НИЙЛБЭР КОЭФФИЦИЕНТ, БҮЛЭГ, ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Бүлэг	Хувилбар	Хугацаа					
		2010-2015	2015-2020	2020-2025	2025-2030	2030-2035	2035-2040
1-р бүлэг	Аажим	2.4	2.4	2.4	2.4	2.4	2.3
	Дунд	2.3	2.3	2.2	2.1	2.1	2.1
	Хурдан	2.2	2.1	2.0	1.9	1.8	1.8
2-р бүлэг	Аажим	2.5	2.5	2.5	2.5	2.4	2.4
	Дунд	2.4	2.4	2.3	2.2	2.2	2.1
	Хурдан	2.3	2.2	2.1	2.0	1.9	1.8
3-р бүлэг	Аажим	2.6	2.6	2.6	2.6	2.6	2.6
	Дунд	2.5	2.5	2.4	2.3	2.3	2.3
	Хурдан	2.5	2.3	2.2	2.1	2.0	1.9
4-р бүлэг	Аажим	3.3	3.3	3.3	3.3	3.3	3.3
	Дунд	3.2	3.1	3.1	3.0	2.9	2.9
	Хурдан	3.1	3.0	2.8	2.7	2.5	2.5
5-р бүлэг	Аажим	2.4	2.3	2.3	2.3	2.3	2.3
	Дунд	2.3	2.2	2.2	2.1	2.0	2.0
	Хурдан	2.2	2.1	2.0	1.9	1.8	1.7
Улсын дүн	Аажим	2.6	2.5	2.5	2.5	2.5	2.5
	Дунд	2.5	2.4	2.3	2.3	2.2	2.2
	Хурдан	2.4	2.3	2.2	2.1	2.0	1.9

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент (НБТК)-ийг тооцохдоо НҮБ-ын Азийн загварыг сонгож, хувийн жингээр нь тархаасан. ТНК-ийн хувилбаруудын 2040 оны утгад харгалзах НБТК-ийг тооцохдоо интерполяци хийв.

Дэвшүүлж байгаа таамаглалаас үзэхэд эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх хамгийн идэвхтэй үе 20 наснаас эхэлж өссөөр, оргил үе нь 25-29 насанд байж, цаашид огцом буурсан нь манай улсын хүн амын насны бүлэг дэх төрөлтийн коэффициентийн одоогийн хандлагатай ойролцоо байна.

ЗУРАГ 3.1.4. ТӨРӨЛТИЙН ДУНД БУУРАЛТТАЙ ХУВИЛБАРЫН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ТӨРӨЛТИЙН КОЭФФИЦИЕНТ, БҮЛГЭЭР, 2010, 2040 ОН



3.2. НАС БАРАЛТЫН ТААМАГЛАЛ

УЛСЫН ТҮВШНИЙ НАС БАРАЛТЫН ТААМАГЛАЛ

Хүн амын хэтийн тооцооны таамаглалд нас баралтын үзүүлэлтийг тодорхойлохдоо дундаж наслалтыг гол болгодог. Дундаж наслалт нь насжилтын хүснэгтийг тооцох үед төрсөн хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацаагаар (жил) илэрхийлэгдэнэ. Мөн насжилтын хүснэгт зохиож байх үед тодорхой насыг насалсан хүний цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг ч тодорхойлдог. Ингэснээрээ тооллогын дүнгээрх хүн амын тоог үндэслэн, нас баралтын тухайн жилийн болон олон жилийн дунджид суурилан тооцсон насжилтын хүснэгтийн тооцоо нь хэтийн тооцооны нас баралтын төсөөлөл болдог.

Хүн амын дундаж наслалтын хэмжээ тухайн үеийн нялхсын нас баралтын түвшнээс шууд хамаарна. Манай улсын хүн амын дундаж наслалт 2000 онд эрэгтэйчүүд 62.05 жил, эмэгтэйчүүд 67.90 жил байсан ба 2009 он хүртэл тогтвортой нэмэгдэж, эрэгтэйчүүд 65.22 жил, эмэгтэйчүүд 72.97 жил болсон. Харин 2010 онд дундаж наслалт бага зэрэг буурч, эрэгтэйчүүд 64.08 жил, эмэгтэйчүүд 72.40 жил болов.

ХҮСНЭГТ 3.2.1. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, ЛОЖИСТИКИЙН АРГААР, ХҮЙСЭЭР, 2010-2040 ОН


Он	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Зөрүү
2010	64.55	74.17	69.27	9.62
2015	65.82	76.11	70.86	10.29
2020	67.06	77.48	72.17	10.42
2025	68.24	78.40	73.22	10.15
2030	69.37	78.99	74.09	9.63
2035	70.42	79.37	74.81	8.96
2040	71.38	79.61	75.42	8.23

Орчин үеийн анагаах ухааны ололт, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, чанар нь сайжрах тутам нялхсын эндэгдэл буурч, дундаж наслалт 2040 он хүртэл жилд дунджаар 0.2 насаар нэмэгдэхээр байна.


Нялхсын эндэгдэл (амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл) 2000 онд 37.0 байснаа 2005 онд 23.1, 2010 онд 22.7 болж буурсан. Хүн амын 2040 оны дундаж наслалтад харгалзах нялхсын эндэгдэл эрэгтэй 18.4, эмэгтэй 14.0 байх төлөвтэй.

Насжилтын хүснэгтээс хүн амын хэтийн тооцоонд ашиглах нэг гол үзүүлэлт бол насны бүлэг дэх нас барах магадлал юм. Нас барах магадлал (qx) нь тодорхой насыг насалсан хүн амын тоо дараагийн насанд шилжихдээ хэд нь нас барахыг харуулдаг үзүүлэлт юм. Жишээлбэл, нэг настай хүүхэд хоёр нас хүртлээ нэг жилийн хугацаанд хэд нь нас барахыг илэрхийлнэ. Өнгөрсөн 10 жилийн хугацааны хүн амын нас барах магадлалыг авч үзэхэд НҮБ-ын Алс дорнодын загвар (UN Far East model)-ын үр дүнтэй их ойролцоо гарсан. Тиймээс ирээдүйн хүн амын нас барах магадлалыг насны бүлэг бүрээр нь тус загвараар тодорхойлогдоно гэж үзлээ.

ЗУРАГ 3.2.1. ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН НАС БАРАХ МАГАДЛАЛ, НАСААР, 2000, 2040 ОН



ЗУРАГ 3.2.2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НАС БАРАХ МАГАДЛАЛ, НАСААР, 2000, 2040 ОН



Дээрх зургаас үзэхэд дэвшүүлсэн загвар манай улсын хүн амын насны бүлэг дэх нас баралтын коэффициентийн өөрчлөлтийн ерөнхий зүй тогтол хэвээр хадлагдахаар байна.

БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН НАС БАРАЛТЫН ТААМАГЛАЛ


Тооллогын хүн амын тоо, нас, хүйсийн мэдээлэлд үндэслэн сүүлчийн 10 жилийн хугацааны дундаж наслалтыг бүлэг тус бүрээр тооцов. Тооцооны дүнгээс үзэхэд төрөлтийн түвшин өндөртэй аймгуудад дундаж наслалт бага, харин төрөлтийн түвшин багатай аймгуудад дундаж наслалт өндөр гарсан. Бүлгийн дундаж наслалтын ирээдүйн чиг хандлагыг улсын түвшнийхтэй ижил байхаар тооцов.

ХҮСНЭГТ 3.2.2. ТААМАГЛАСАН ДУНДАЖ НАСЛАЛТ, БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010-2040 ОН

Бүлэг		2010-2015	2015-2020	2020-2025	2025-2030	2030-2035	2035-2040
1-р бүлэг	Эрэгтэй	65.96	67.20	68.39	69.52	70.57	71.54
	Эмэгтэй	76.05	77.42	78.34	78.93	79.31	79.55
2-р бүлэг	Эрэгтэй	65.96	67.19	68.38	69.51	70.56	71.53
	Эмэгтэй	74.97	76.31	77.22	77.81	78.18	78.42
3-р бүлэг	Эрэгтэй	65.26	66.48	67.66	68.78	69.82	70.77
	Эмэгтэй	75.51	76.87	77.78	78.37	78.75	78.99
4-р бүлэг	Эрэгтэй	64.93	66.14	67.32	68.43	69.46	70.41
	Эмэгтэй	73.41	74.73	75.62	76.19	76.56	76.79
5-р бүлэг	Эрэгтэй	68.64	69.93	71.16	72.34	73.43	74.44
	Эмэгтэй	79.24	80.21	80.71	80.88	80.81	80.61
Улсын дүн	Эрэгтэй	65.82	67.06	68.24	69.37	70.42	71.38
	Эмэгтэй	76.11	77.48	78.40	78.99	79.37	79.61

Таамаглалаар цаашид нялхсын эндэгдэл буурч, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 2040 он хүртэл жилд дунджаар 0.2, эмэгтэйчүүдийнх 0.1 насаар нэмэгдэж, эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү багасах тооцоо гарав. Үүний дотор төрөлтийн түвшин хамгийн бага байгаа 5-р бүлэгт дундаж наслалт өндөр байхад, төрөлтийн түвшин хамгийн өндөртэй 4-р бүлэгт дундаж наслалт хамгийн бага байх хандлагатай байна. Тус түвшний хэтийн тооцоонд шилжин амьдрах магадлалыг НҮБ-ын Алс дорнодын загвараар тооцлоо.

ЗУРАГ 3.2.3. НАС БАРАХ МАГАДЛАЛ, БҮЛЭГ, НАС, ХҮЙСЭЭР, 2010, 2040 ОН



3.3. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТААМАГЛАЛ

Шилжих хөдөлгөөний таамаглалыг боловсруулахдаа улсын түвшинд зөвхөн 1-р багц хувилбарт гадаад шилжих хөдөлгөөнийг, бүс, аймаг, нийслэлийн түвшинд гадаад болон дотоод шилжих хөдөлгөөнийг тус бүрд нь тооцов.

Бүс, аймаг, нийслэлийн түвшинд шилжих хөдөлгөөний таамаглалыг дэвшүүлэхдээ тооцоонд ашиглах суурь хүн амаас нь хамааруулаад 2 хувилбараар авч үзэв. Үүнд:

- Монгол Улсын хүн амд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоог оруулсан тооцоонд зөвхөн дотоод шилжих хөдөлгөөнийг;
- Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоонд үндэслэсэн тооцоонд дотоод, гадаад шилжих хөдөлгөөний таамаглалыг боловсруулж ашигласан.

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТААМАГЛАЛ

Дотоод шилжих хөдөлгөөний таамаглалыг боловсруулахдаа Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоос сүүлчийн 10 жилийн шилжих хөдөлгөөний мэдээллийг судалж, цаашдын хандлагыг тодорхойлсон. Ингэхдээ зөвхөн аймаг, нийслэл хооронд шилжих хөдөлгөөнд оролцогчдыг хамгийн сүүлд шилжин ирсэн аймаг, нийслэлдээ байнга сууж байгаа хугацаагаар авч үзлээ.

Сүүлчийн 10 жилд дотоод шилжих хөдөлгөөнд 594519 хүн оролцсоноос Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг болон Улаанбаатар хотод шилжих хөдөлгөөний эерэг урсгалтай, бусад аймагт сөрөг урсгалтай байв. Шилжих хөдөлгөөнд оролцсон нийт хүн амын хүйсийн харьцаа 99 боловч аймаг, нийслэлд их ялгаатай, аймгуудад шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд, шилжин явагчдын дунд эмэгтэйчүүд давамгайлж байжээ. Харин насны бүтцийн хувьд 15-34 насныхан өндөр хувь эзэлж байна. Шилжих хөдөлгөөнд оролцогчдыг хугацаагаар нь ангилж үзвэл 2001 оноос хойш аажим боловч тасралтгүй нэмэгдсээр иржээ. Шилжих хөдөлгөөний өнгөрсөн 10 жилийн дүр төрхийг хэтийн тооцоонд ашиглахад хүндрэлтэй байв. Учир нь хүн амын шилжих хөдөлгөөн нь тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдаж огцом өөрчлөгдөж байдаг.


Шилжих хөдөлгөөний таамаглал боловсруулахдаа цэвэр шилжих хөдөлгөөнд оролцогчид 2010-2020 онд 6 хувь, 2021-2030 онд 6-18 хувь, 2031-2040 онд 18-30 хувиар буурна гэж үзсэн. Мөн шилжих хөдөлгөөнд оролцогчдын хүйсийн харьцаа аажмаар тэнцвэржиж, 2040 он гэхэд шилжих хөдөлгөөнд оролцогч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо ойролцоо байхаар тооцоолсон.

ХҮСНЭГТ 3.3.1. ХҮН АМЫН ДОТООД ЦЭВЭР ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТААМАГЛАЛ, БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010-2040 ОН

Бүлэг		2006-2010	2011-2015	2016-2020	2021-2025	2026-2030	2031-2035	2036-2040
1-р бүлэг	Бүгд	-2380	-2332	-2192	-1929	-1582	-1202	-842
	Эрэгтэй	-1146	-1123	-1056	-929	-762	-579	-405
	Эмэгтэй	-1234	-1209	-1137	-1000	-820	-623	-436
2-р бүлэг	Бүгд	-7898	-7740	-7276	-6403	-5250	-3990	-2793
	Эрэгтэй	-3255	-3190	-2999	-2639	-2164	-1644	-1151
	Эмэгтэй	-4643	-4550	-4277	-3764	-3086	-2346	-1642
3-р бүлэг	Бүгд	-6808	-6672	-6272	-5519	-4526	-3439	-2408
	Эрэгтэй	-3083	-3021	-2840	-2499	-2049	-1558	-1090
	Эмэгтэй	-3725	-3651	-3431	-3020	-2476	-1882	-1317
4-р бүлэг	Бүгд	-4964	-4865	-4573	-4024	-3300	-2508	-1755
	Эрэгтэй	-2469	-2420	-2274	-2002	-1641	-1247	-873
	Эмэгтэй	-2495	-2445	-2298	-2023	-1659	-1260	-882
5-р бүлэг	Бүгд	22050	21609	20312	17875	14657	11140	7798
	Эрэгтэй	9953	9754	9169	8068	6616	5028	3520
	Эмэгтэй	12097	11855	11144	9807	8041	6111	4278

Шилжих хөдөлгөөнд оролцогчдын дотор 15-39 насныхан хамгийн өндөр хувь эзэлж байгаа боловч шилжих хөдөлгөөнд оролцогчдын насны бүтэц цаашид одоогийнхтой ойролцоо түвшинд хадгалагдахаар тооцоо гарч байна.

ЗУРАГ 3.3.1. ДОТООД ЦЭВЭР ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, 2010 ОН



ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТААМАГЛАЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор гадаадад оршин суугаа иргэдээ тоолсноос гадна гадаадаас шилжин ирсэн монголчууд болон Монгол Улсад 6, түүнээс дээш сарын хугацаатай оршин суугаа гадаадын харьяат иргэдийн мэдээллийг цуглуулсан нь шилжих хөдөлгөөний таамаглалыг дэвшүүлэх үндсэн мэдээлэл болов.

ХҮСНЭГТ 3.3.2. ХҮН АМЫН ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ, 2000-2010 ОН

Он	Шилжин ирсэн гадаадын харьяат иргэн болон гадаадад байнгаоршин сууж байгаад ирсэн МУ-ын иргэд	Гадаадад шилжин явсан Монгол Улсын иргэн	Цэвэр шилжих хөдөлгөөн
2010	19 011	16 793	2 218
2009	5 460	17 984	-12 524
2008	4 460	17 553	-13 093
2007	3 363	13 161	-9 798
2006	2 800	11 460	-8 660
2005	3 209	7 941	-4 732
2004	1 449	4 763	-3 314
2003	1 043	4 031	-2 988
2002	805	2 632	-1 827
2001	628	3 831	-3 203
2000	1 176	2 094	-918
Нийт	43 404	102 243	-58 839

Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого

Дээрх хүснэгтээс харахад сүүлчийн 10 жилд гадаад шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Шилжин ирсэн иргэдийн мэдээллээс харахад 2000-2009 оны хооронд аажим өсч байсан бол 2010 онд өмнөх оноос 3.5 дахин нэмэгдэв. Мөн шилжин явсан иргэдийн тоо 2000-2009 оны хооронд өсч байсан бол 2010 онд өмнөх онохоос буурсан нь цэвэр шилжих хөдөлгөөнийг эергээр төсөөлөх үндэслэл болж байна. Мөн Монгол Улсад уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжиж, түүнийг дагасан бусад салбарын үйл ажиллагаа идэвхижсэн нь гадаадын ажиллах хүчнийг татахын зэрэгцээгээр гадаадад суугаа МУ-ын иргэд эх орондоо ирэх болсныг 2010 оны гадаад шилжих хөдөлгөөний мэдээллээс харж болно.


Гадаад шилжих хөдөлгөөний 2010 оны чиг хандлага цаашдаа 2020 он хүртэл хэвээр хадгалагдаж, цаашид аажмаар буурна гэж тооцов. Харин монгол иргэдийн гадагш чиглэсэн хөдөлгөөний 2005-2010 оны чиг хандлага ирэх 5 жилд хэвээр хадгалагдаж, цаашид нэмэгдэн, гадаад цэвэр шилжих хөдөлгөөн эерэг байхаар төсөөлөв.

ХҮСНЭГТ 3.3.3. ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТААМАГЛАЛ, 2010-2040 ОН

Он	Шилжин ирэх хөдөлгөөн	Шилжин явах хөдөлгөөн	Цэвэр шилжих хөдөлгөөн
2010-2015	110 264	72 333	37 931
2015-2020	104 751	67 993	36 757
2020-2025	99 513	63 914	35 599
2025-2030	94 537	60 079	34 459
2030-2035	98 811	56 474	33 337
2035-2040	85 320	53 086	32 234

Шилжин явсан хүн амын насны бүтцийг тодорхойлохдоо 2010 оны тооллогоор гадаадад тоологдсон хүн амын насны бүтэц хадгалагдана гэж таамагласан. Харин шилжин ирсэн хүн амын насны бүтцийн хувьд гадаадад оршин суугаа МУ-ын иргэд 5-10 жилийн дараа эх орондоо эргэж ирэхээр тооцов. Түүнчлэн, сүүлчийн 10 жилд гаднаас шилжин ирсэн гадаад иргэдийн насны бүтцийг мөн харгалзсан болно.

ЗУРАГ 3.3.2. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮ, ХУВИЙН ЖИНГЭЭР, 2010-2040 ОН



Энэхүү бүтцээс үзэхэд, 2010-2040 онд 57.7 хувь нь эрэгтэй, 42.3 хувь нь эмэгтэйчүүд байх бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын хөдөлгөөн давамгайлсан хэвээр байна.



Бүс, аймаг, нийслэлийн түвшний гадаад шилжих хөдөлгөөний таамаглалыг авч үзэхдээ улсын түвшний гадаад цэвэр шилжих хөдөлгөөний дүнг бүлэг бүрт тархах хэлбэрээр боловсруулав. Ингэхдээ гадаадаас шилжин ирэх урсгалыг Монгол Улсаас хамгийн сүүлд шилжин явсан аймаг, нийслэл рүү, насны бүтцийн хувьд мөн улсын дүнд дэвшүүлсэн бүтэц хадгалагдана гэж үзлээ.

ХҮСНЭГТ 3.3.4. ГАДААД ЦЭВЭР ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТААМАГЛАЛ,
БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010-2040 ОН

Хугацаа		2011-2015	2016-2020	2021-2025	2026-2030	2031-2035	2036-2040
1-р бүлэг	Бүгд	685	665	643	623	603	583
	Эрэгтэй	405	393	380	368	356	344
	Эмэгтэй	280	272	263	255	247	239
2-р бүлэг	Бүгд	395	383	372	357	350	335
	Эрэгтэй	245	237	230	220	216	207
	Эмэгтэй	150	146	142	137	134	128
3-р бүлэг	Бүгд	311	300	294	282	273	264
	Эрэгтэй	193	185	182	175	169	163
	Эмэгтэй	118	115	112	107	104	101
4-р бүлэг	Бүгд	350	340	329	319	309	298
	Эрэгтэй	219	213	206	200	194	187
	Эмэгтэй	131	127	123	119	115	111
5-р бүлэг	Бүгд	5845	5664	5482	5311	5132	4967
	Эрэгтэй	3312	3211	3107	3011	2909	2816
	Эмэгтэй	2533	2453	2375	2300	2223	2151
Улсын дүн	Бүгд	7586	7352	7120	6892	6667	6447
	Эрэгтэй	4374	4239	4105	3974	3844	3717
	Эмэгтэй	3212	3113	3015	2918	2823	2730

ДӨРӨВЛҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН ХЭТИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН




Энэ бүлэгт хүн амын хэтийн тооцооны улс, аймаг, нийслэлийн түвшний үндсэн үр дүнг нэгтгэн орууллаа. Тооцоог төрөлтийн түвшнээс хамааруулан 3 хувилбараар, суурь хүн амаас хамааруулан 2 төрлөөр боловсруулсныг өмнө дурдсан. Бодлого, төлөвлөлт, судалгаа, шинжилгээнд ашиглахад тохиромжтой нь хүн амын өсөлт их хурдацтай бус, бас хэт удаан биш дунд хувилбар юм. Гэхдээ аль ч хувилбарын тооцоог хэрэглэгч өөрсдийн хэрэгцээнд тохируулан ашиглах нь нээлттэй билээ. Тиймээс хүн амын хэтийн тооцооны үр дүнг танилцуулахад дараах хувилбараар тооцсон хүн амын тоо, өсөлт, бүтцийн талаар голлон авч үзлээ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоог үндэслэн тооцсон, төрөлтийн дундаж бууралттай "1Б" хувилбар;
- Монгол Улсын хүн амд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоог оруулсан, төрөлтийн дундаж бууралттай "2Б" хувилбар орж байна.

4.1. ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТИЙН ХҮРД

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоог үндэслэн тооцсон, төрөлтийн дундаж бууралттай "1Б" хувилбараар Монгол Улсын хүн ам 2017 оны эхэнд 3 сая, 2040 онд 3.9 саяд хүрэхээр байна. Харин төрөлтийн хурдацтай бууралттай "1В" хувилбараар 2018 онд 3 сая, 2040 онд 3.7 сая, төрөлтийн аажим бууралттай "1А" хувилбараар 2017 оны дундуур 3 сая, 2040 онд 4.1 саяд хүрэх төлөвтэй байна. Харин Монгол Улсын хүн амд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоог оруулсан, төрөлтийн дундаж бууралттай "2Б" хувилбараар 2016 оны эхээр 3 сая, 2040 онд 3.9 сая болно гэсэн тооцоо гарч байна. Төрөлтийн хурдацтай бууралттай "2В" хувилбараар 2016 онд 3 сая, 2040 онд 3.7 сая, төрөлтийн аажим бууралттай "2А" хувилбараар 2015 онд 3 сая, 2040 онд 4.1 саяд хүрэхээр байна (хүснэгт 4.1.1).

ЗУРАГ 4.1.1. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, "1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН



Тооцооны "1Б" хувилбараар 2035 он хүртэл хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1 хувиас илүү байсан бол цаашид буурч, 2040 онд 0.77 болж, 2010 оны түвшнээс 1.2 пунктээр буурахаар байна. Харин "2Б" хувилбараар хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 2026 он хүртэл 1 хувиас илүү байсан бол үүнээс цааш буурсаар 2040 онд 0.87 болно.

ХҮСНЭГТ 4.1.1. ХҮН АМЫН ТОО, ХУВИЛБАР БҮРЭЭР, 2010-2040 ОН

Он	"1А" хувилбар	"1Б" хувилбар	"1В" хувилбар	"2А" хувилбар	"2Б" хувилбар	"2В" хувилбар
2010	2 633 312	2 633 312	2 633 312	2 739 001	2 739 001	2 739 001
2011	2 687 155	2 684 801	2 683 930	2 789 662	2 786 971	2 786 092
2012	2 743 133	2 737 520	2 735 586	2 842 415	2 836 026	2 834 083
2013	2 800 295	2 790 729	2 787 522	2 896 304	2 885 464	2 882 245
2014	2 857 687	2 843 816	2 839 081	2 950 332	2 934 676	2 929 915
2015	2 915 044	2 896 623	2 890 060	3 004 232	2 983 508	2 976 895
2016	2 972 092	2 948 987	2 940 256	3 057 719	3 031 800	3 022 981
2017	3 028 579	3 000 752	2 989 479	3 110 522	3 079 391	3 067 975
2018	3 084 319	3 051 786	3 037 562	3 162 439	3 126 140	3 111 700
2019	3 139 139	3 101 950	3 084 340	3 213 292	3 171 908	3 153 989
2020	3 192 856	3 151 086	3 129 658	3 262 903	3 216 543	3 194 699
2021	3 245 304	3 199 038	3 173 376	3 311 117	3 259 896	3 233 697
2022	3 296 359	3 245 683	3 215 388	3 357 813	3 301 850	3 270 887
2023	3 345 977	3 290 961	3 255 707	3 402 948	3 342 350	3 306 288
2024	3 394 197	3 334 878	3 294 419	3 446 571	3 381 406	3 339 999
2025	3 441 144	3 377 503	3 331 628	3 488 821	3 419 099	3 372 135
2026	3 486 997	3 418 935	3 367 464	3 529 907	3 455 557	3 402 857
2027	3 531 996	3 459 336	3 402 115	3 570 108	3 490 974	3 432 385
2028	3 576 458	3 498 959	3 435 819	3 609 761	3 525 616	3 460 975
2029	3 620 710	3 538 068	3 468 819	3 649 204	3 559 756	3 488 881
2030	3 665 017	3 576 877	3 501 325	3 688 694	3 593 599	3 516 302
2031	3 709 470	3 615 372	3 533 295	3 728 442	3 627 235	3 543 295
2032	3 754 191	3 653 556	3 564 687	3 768 712	3 660 786	3 569 932
2033	3 799 405	3 691 662	3 595 762	3 809 742	3 694 493	3 596 480
2034	3 845 235	3 729 850	3 626 701	3 851 654	3 728 518	3 623 123
2035	3 891 702	3 768 128	3 657 458	3 894 458	3 762 859	3 649 804
2036	3 938 689	3 806 375	3 687 865	3 938 065	3 797 414	3 676 365
2037	3 986 036	3 844 422	3 717 704	3 982 354	3 832 041	3 702 607
2038	4 032 602	3 881 142	3 745 859	4 027 237	3 866 666	3 728 464
2039	4 077 215	3 915 385	3 771 203	4 072 607	3 901 192	3 753 861
2040	4 119 723	3 946 997	3 793 558	4 118 322	3 935 473	3 778 621

Хэтийн тооцооны бүх хувилбарт жилийн дундаж өсөлтийн хурд 2012 он хүртэл бага зэрэг өсч, түүнээс цааш тогтвортой буурч 2028 оноос тогтворжиж, 2037 оноос дахин багасах хандлагатай байна (хүснэгт 4.1.2).

ХҮСНЭГТ 4.1.2. ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, ХУВИЛБАР БҮРЭЭР, 2010-2040 ОН

Он	"1А"	"1Б"	"1В"	"2А"	"2Б"	"2В"	Он	"1А"	"1Б"	"1В"	"2А"	"2Б"	"2В"
2010	2.00	1.93	1.90	1.81	1.73	1.70	2026	1.30	1.20	1.05	1.15	1.04	0.88
2011	2.05	1.95	1.91	1.86	1.74	1.71	2027	1.26	1.16	1.00	1.12	1.00	0.85
2012	2.08	1.94	1.90	1.89	1.75	1.71	2028	1.24	1.12	0.97	1.09	0.97	0.81
2013	2.05	1.91	1.86	1.87	1.71	1.66	2029	1.22	1.10	0.94	1.08	0.95	0.79
2014	2.01	1.86	1.81	1.83	1.67	1.62	2030	1.21	1.08	0.92	1.07	0.94	0.77
2015	1.97	1.82	1.75	1.79	1.63	1.57	2031	1.20	1.06	0.90	1.07	0.93	0.76
2016	1.91	1.77	1.69	1.74	1.58	1.51	2032	1.20	1.04	0.87	1.08	0.92	0.74
2017	1.85	1.71	1.63	1.69	1.53	1.45	2033	1.20	1.03	0.86	1.09	0.92	0.74
2018	1.79	1.66	1.56	1.63	1.48	1.38	2034	1.20	1.03	0.85	1.10	0.92	0.74
2019	1.73	1.60	1.49	1.56	1.43	1.32	2035	1.20	1.02	0.84	1.11	0.92	0.73
2020	1.66	1.54	1.42	1.50	1.37	1.25	2036	1.20	1.00	0.82	1.12	0.91	0.72
2021	1.60	1.48	1.35	1.43	1.31	1.18	2037	1.19	0.99	0.79	1.12	0.90	0.70
2022	1.53	1.42	1.28	1.37	1.25	1.11	2038	1.13	0.92	0.72	1.12	0.90	0.69
2023	1.46	1.36	1.21	1.30	1.19	1.05	2039	1.07	0.84	0.63	1.12	0.88	0.67
2024	1.40	1.30	1.15	1.24	1.13	0.99	2040	1.01	0.77	0.55	1.11	0.87	0.65
2025	1.35	1.24	1.10	1.19	1.08	0.93							

Төрөлтийн аажим бууралттай "1А", "2А" хувилбарын тооцоогоор хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд бараг бүх онд 1 хувиас илүү байна. Харин төрөлтийн хурдацтай бууралттай "1В" хувилбараар жилийн дундаж өсөлт 2027 оноос хойш 1 хувиас бага, 2040 онд 0.52 хувь болох юм. Харин "2В" хувилбараар 2024 оноос хойш 1 хувиас бага түвшинд хүрч 2040 онд 0.55 болох төлөвтэй байна.

Хүн амын төрөлтийн хэмжээг ижил байх таамаглалтай тооцсон хувилбаруудын жилийн дундаж өсөлт өөр байгаа нь шилжих хөдөлгөөнөөс хамаарч байна.

4.2. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын нас, хүйсийн бүтэц төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний нөлөөгөөр өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл, хүн амын төрөлт, нас баралт буурч, дундаж наслалт нэмэгдсэнээр залуу насны хүн амын хувийн жин буурч, ахимаг насныхны хувийн жин нэмэгдэнэ.

Олон улсад хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг 3 үндсэн бүлэг болгож судалдаг. Үүнд:

- Хүүхэд 0-14 нас
- Идэр 15-64 нас
- Хөгшин 65, түүнээс дээш орно.

Хүн ам зүйн судалгаанд 0-14 насны хүүхдийн бүх хүн амд эзлэх хувийн жин 35 хувиас дээш бол насны "залуу" бүтэцтэй буюу 25 хувиас бага бол "хөгшин" насны бүтэцтэй гэж үздэг¹. Хэтийн тооцооны "1В" хувилбарын дүнгээс үзэхэд манай улсын нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 онд 28.0 байснаа 2015 онд 27.7, 2025 онд 26.0, 2040 онд 21.4 болох төлөвтэй байна.

¹ Якоб С.Сийгел, Давид А.Свансон, Хүн ам зүйн арга ба материалууд, Хянан тохиолдуулсан хоёрдугаар хэвлэл, 159 дүгээр тал.

Нөгөө талаас 65, түүнээс дээш настай хүн амын бүх хүн амд эзлэх хувь 10, түүнээс дээш бол насны бүтцийн хувьд “Хөгшин” бүтэцтэй буюу 5 хувиас бага бол “залуу” насны бүтэцтэй гэж үздэг². Хэтийн тооцооны “15” хувилбараар тооцсон дүнгээс үзэхэд манай улсын нийт хүн амд 65, түүнээс дээш насныхны эзлэх хувийн жин 2010 онд 3.8 хувь байсан бол энэ үзүүлэлт 2025 онд 6.0, 2040 онд 11.4 болох төлөвтэй байна (хүснэгт 4.2.1).

ХҮСНЭГТ 4.2.1. ХҮН АМЫН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ХУВИЙН ЖИН, “15” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Насны бүлэг	2010	2011	2012	2015	2020	2025	2030	2035	2040
0-4	10.9	11.0	11.0	10.3	9.4	8.3	7.5	7.4	7.6
5-9	8.2	8.3	8.6	9.9	9.5	8.8	7.9	7.1	7.0
10-14	8.9	8.6	8.2	7.5	9.2	8.9	8.4	7.5	6.8
0-14	28.0	27.8	27.7	27.7	28.1	26.0	23.7	22.0	21.4
15-19	9.7	9.3	9.0	8.1	6.8	8.5	8.4	7.9	7.1
20-24	11.0	10.7	10.2	8.7	7.3	6.2	7.9	7.8	7.5
25-29	9.4	9.6	9.8	10.0	7.9	6.8	5.9	7.5	7.4
30-34	8.4	8.4	8.5	8.7	9.3	7.6	6.5	5.7	7.2
35-39	7.6	7.7	7.7	7.8	8.2	8.9	7.3	6.4	5.6
15-39	46.2	45.7	45.2	43.3	39.5	37.9	36.0	35.3	34.9
40-44	6.8	6.8	6.9	7.1	7.3	7.7	8.5	7.1	6.2
45-49	6.0	6.1	6.1	6.2	6.6	6.9	7.4	8.1	6.8
50-54	4.6	4.8	5.0	5.4	5.7	6.1	6.5	6.9	7.6
55-59	2.7	3.0	3.2	4.0	4.8	5.1	5.6	6.0	6.4
60-64	1.9	1.9	2.0	2.3	3.5	4.2	4.5	5.0	5.4
40-64	22.0	22.6	23.2	25.1	27.8	30.0	32.4	33.0	32.4
65-69	1.4	1.4	1.4	1.5	1.9	2.9	3.5	3.9	4.3
70-74	1.1	1.1	1.1	1.1	1.2	1.5	2.3	2.9	3.2
75+	1.3	1.3	1.3	1.4	1.5	1.6	2.0	2.9	3.8
65, дээш	3.8	3.9	3.9	4.0	4.5	6.0	7.9	9.7	11.4
ХАЗА	46.7	46.4	46.2	46.4	48.4	47.1	46.2	46.3	48.8

Харин Монгол Улсын хүн амаар тооцсон “25” хувилбарын тооцооны үр дүнгээс үзэхэд нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 онд 27.3 байснаа 2015 онд 27.7, 2025 онд 26.8, 2040 онд 22.0 болохоор байна. Харин 65, түүнээс дээш настай хүн амын нийт хүн амд эзлэх хувь 2010 онд 3.7 хувь байсан бол энэ үзүүлэлт 2025 онд 5.9, 2040 онд 11.0 болох төлөвтэй (хүснэгт 4.2.2).

² Якоб С.Сийгел, Давид А.Свансон, Хүн ам зүйн арга ба материалууд, Хянан тохиолдуулсан хоёрдугаар хэвлэл, 159 дүгээр тал.

ХҮСНЭГТ 4.2.2. ХҮН АМЫН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ХУВИЙН ЖИН,
“25” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Насны бүлэг	2010	2011	2012	2015	2020	2025	2030	2035	2040
0-4	10.6	10.9	11.0	10.6	9.7	8.5	7.6	7.6	7.9
5-9	8.0	8.1	8.4	9.7	9.8	9.1	8.1	7.3	7.2
10-14	8.7	8.3	8.0	7.3	9.0	9.2	8.7	7.7	6.9
0-14	27.3	27.3	27.3	27.7	28.6	26.8	24.3	22.5	22.0
15-19	9.7	9.2	8.9	8.0	6.8	8.5	8.8	8.3	7.3
20-24	11.3	11.0	10.5	8.9	7.4	6.3	8.0	8.4	7.9
25-29	9.8	9.9	10.2	10.4	8.2	6.9	6.0	7.6	8.0
30-34	8.7	8.7	8.7	8.9	9.5	7.6	6.6	5.7	7.3
35-39	7.8	7.9	7.9	7.9	8.2	8.9	7.2	6.2	5.4
15-39	47.3	46.7	46.1	44.0	40.0	38.3	36.6	36.2	35.9
40-44	6.8	6.8	6.9	7.1	7.2	7.6	8.4	6.8	5.9
45-49	5.9	6.0	6.0	6.1	6.4	6.7	7.1	7.9	6.5
50-54	4.5	4.7	4.9	5.2	5.5	5.9	6.2	6.6	7.4
55-59	2.6	2.9	3.1	3.9	4.6	4.9	5.3	5.7	6.1
60-64	1.8	1.8	1.9	2.2	3.3	4.0	4.4	4.8	5.1
40-64	21.7	22.2	22.8	24.5	27.0	29.0	31.4	31.8	31.0
65-69	1.4	1.4	1.4	1.5	1.8	2.8	3.4	3.8	4.2
70-74	1.1	1.1	1.1	1.1	1.1	1.5	2.3	2.8	3.1
75+	1.2	1.3	1.3	1.3	1.4	1.6	1.9	2.8	3.8
65, дээш	3.7	3.7	3.7	3.9	4.4	5.9	7.7	9.4	11.0
ХАЗА	45.0	45.0	45.0	46.1	49.1	48.6	47.1	46.9	49.4

Тиймээс тооцооны аль ч хувилбараас харсан Монгол Улсын хүн ам 2030-аад оноос эхлэн насны “хөгшин” бүтэцтэй болох хандлага ажиглагдлаа.

Хүн амын хүйсийн харьцаа 100 эмэгтэй хүн амд ногдох эрэгтэйн тоогоор илэрхийлэгддэг. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амаар тооцсон, төрөлтийн дундаж бууралттай “15” хувилбараар хүйсийн харьцаа 2010 онд 98.5 хувь байснаа 2040 онд 95.6 хувь болж буурч байна. Энэ нь улс орон хөгжиж, эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах тутам дундаж наслалт, тэр дундаа эмэгтэйчүүдийн дундаж наслалт илүү нэмэгддэгтэй холбоотой юм.

Хүйсийн харьцаа насны бүлэг бүрээр өөрчлөгдөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, хүйсийн харьцаа 2010 онд 30-34 хүртэлх насанд их байсан бол 2040 онд 45-49 насанд өндөр байх төлөвтэй байна. Үүнийг гадаадаас хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд илүү шилжин ирж байгаагаар тайлбарлаж болох юм.

Нас ахих тусам хүйсийн харьцаа буурах нь бүх онд нийтлэг байгаа хэдий ч 2030 оноос хойш илүү хурдацтай буурах тооцоо гарав. Өөрөөр хэлбэл, 2010 онд 75-аас дээш насанд хүйсийн харьцаа 56.8 хувь байсан бол 2040 онд 8.8 пунктээр буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс бага байдаг зүй тогтол цаашид хэвээр хадгалагдахыг илэрхийлнэ. Харин төрөх үеийн хүйсийн харьцаа тооцоо хийсэн онуудад 102.9-103.4 хооронд хэлбэлзэж байна.

**ХҮСНЭГТ 4.2.3. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛЭГ,
“1Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН**

Насны бүлэг	2010	2011	2012	2015	2020	2025	2030	2035	2040
0-4	103.2	103.0	102.9	102.9	102.9	103.0	103.1	103.3	103.4
5-9	103.8	103.8	103.7	102.9	102.6	102.6	102.7	102.9	103.1
10-14	102.8	102.9	103.1	103.6	102.7	102.5	102.5	102.6	102.8
15-19	102.7	102.8	102.8	102.7	103.6	102.7	102.4	102.4	102.5
20-24	101.9	102.0	102.1	102.5	102.5	103.5	102.5	102.3	102.3
25-29	100.8	100.9	101.1	101.6	102.3	102.5	103.5	102.5	102.2
30-34	101.3	101.3	101.2	100.9	101.6	102.5	102.9	104.1	102.6
35-39	99.3	99.6	100.0	101.0	100.6	101.3	102.5	103.1	104.3
40-44	97.0	97.1	97.3	98.1	99.9	99.7	100.6	102.0	102.7
45-49	95.3	95.5	95.5	95.4	96.6	98.5	98.5	99.6	101.2
50-54	90.5	90.8	91.2	92.5	92.7	94.0	96.1	96.6	97.8
55-59	86.5	86.5	86.4	86.3	88.1	88.6	90.2	92.6	93.4
60-64	80.8	80.3	80.2	80.7	80.4	82.2	82.9	84.8	87.6
65-69	82.3	80.1	78.0	73.4	73.0	72.7	74.5	75.5	77.7
70-74	80.5	79.3	77.9	72.6	64.3	63.9	63.6	65.4	66.6
75+	56.8	57.6	58.3	58.7	54.9	49.3	47.4	47.5	48.0
Бүгд	98.5	98.5	98.4	98.1	97.6	97.0	96.4	95.9	95.6


Монгол Улсын хүн амаар тооцсон “2Б” хувилбарын тооцоогоор хүйсийн харьцаа 2010 онд 98.1 байснаа 2040 онд 94.1 болж 4.0 пунктээр буурч байгааг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амаар тооцсон “1Б” хувилбарын тооцоонхтой зэрэгцүүлэхэд нэлээд ялгаатай байна (Хүснэгт 4.2.4).

**ХҮСНЭГТ 4.2.4. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛЭГ,
“2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН**

Насны бүлэг	2010	2011	2012	2015	2020	2025	2030	2035	2040
0-4	103.2	103.0	102.9	102.9	102.9	102.9	103.1	103.2	103.4
5-9	103.7	103.7	103.6	102.8	102.6	102.6	102.7	102.9	103.1
10-14	102.8	102.9	103.1	103.6	102.7	102.4	102.5	102.6	102.8
15-19	102.4	102.4	102.4	102.5	103.4	102.5	102.3	102.3	102.4
20-24	101.7	101.8	101.8	101.9	102.1	103.0	102.2	102.0	102.1
25-29	100.4	100.5	100.6	101.0	101.3	101.6	102.5	101.8	101.7
30-34	99.6	99.6	99.5	99.4	100.1	100.5	101.0	102.1	101.4
35-39	97.7	97.8	97.9	98.3	98.3	99.2	99.7	100.3	101.6
40-44	95.9	95.8	95.7	95.8	96.6	96.9	98.0	98.8	99.6
45-49	94.4	94.3	94.0	93.4	93.6	94.6	95.2	96.6	97.7
50-54	90.1	90.2	90.4	90.9	90.2	90.7	92.1	93.0	94.7
55-59	86.2	86.1	86.0	85.5	86.4	86.0	86.8	88.6	89.9
60-64	80.7	80.1	79.9	80.1	79.4	80.4	80.4	81.6	83.7
65-69	82.2	80.0	77.8	73.0	72.3	71.7	72.8	73.1	74.6
70-74	80.3	79.1	77.7	72.3	63.9	63.2	62.7	63.9	64.5
75+	56.8	57.6	58.3	58.6	54.7	49.0	46.9	46.9	47.0
Бүгд	98.1	97.9	97.8	97.3	96.6	95.8	95.1	94.5	94.1

Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суваргыг 2 хувилбараар 2010, 2040 оноор зэрэгцүүлж дараах зурагт үзүүлэв.


ЗУРАГ 4.2.1. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, "1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010, 2040 ОН



Монгол Улсын хүн амын 2010 оны нас, хүйсийн суваргын хүрээ 5-14 насанд нарийсч байгаа нь 1995-2005 онуудад төрөлт буурснаас шалтгаалсан. Энэ нөлөөлөл 2040 онд 35-44 насанд шилжсэнийг суваргаас харж болно. Харин 2010 оны суваргын суурь 0-4 насанд өргөн байгаа нь 2006-2010 онд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой билээ. Хориос дээш насанд суваргын хэлбэр аажмаар нарийсч байгаа нь 1990-ээд оноос өмнө төрөлт тогтмол өндөр байсантай холбоотой. Хүн амын нас, хүйсийн 2040 оны суваргын хүрээ 0-4, 25-29, 50-54 насанд өргөсч байгаа нь 2010 оны хүн амын насны бүтцээс хамаарч байгаа билээ. 2040 оны суваргын хэлбэрээс харахад ерөнхийдөө 40 дээш насанд олон хүн байгаа нь улсын хүн амын насны бүтэц идэршиж улмаар хөгшрөх хандлагатай болохыг харуулна.

Хүн ам зүйн ачаалал 15-64 насны 100 хүнд ногдох 0-14 ба 65-аас дээш насны хүн амын харьцаагаар илэрхийлэгддэг. Манай улсын хүн ам зүйн ачаалал төрөлт, гадаад шилжих хөдөлгөөний нөлөөллөөс хамаарч нэлээд хэлбэлзэлтэй байх нь зураг 4.2.2-оос харагдаж байна.

ЗУРАГ 4.2.2. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, "1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН



Хэтийн тооцооны “2Б” хувилбараар хүн ам зүйн ачаалал 2010-2017 онд “1Б” хувилбарын тооцооноос бага байгаа нь гадаадад байгаа иргэдийн дийлэнх хөдөлмөрийн насныхан байгаатай холбоотой.

Хүн ам зүйн ачааллыг 0-14 насны хүүхдийн, 65-аас дээш насны хөгшдийн гэж 2 ангилдаг. Хүн ам зүйн ачааллын байдлаас хамааран “Хүн ам зүйн цонх” гэсэн ойлголтыг хэрэглэдэг. Хүн ам зүйн цонх гэдэг нь хүн амын дундаж наслалт нэмэгдэж, төрөлт буурснаар хүн амын өсөлт удааширч, нийгэм, эдийн засагт ач холбогдол бүхий хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин өндөр байх буюу хүн ам зүйн ачаалал бага байх үе юм.

Монгол Улсын хүн амын хэтийн тооцооны “1Б”, “2Б” хувилбарт хүн ам зүйн ачаалал 2010 онд 46.7, 45.0 байсан бол 2040 онд 48.8, 49.4 болж нэмэгдэж байгаагийн дотор хүүхдийн ачаалал буурч, хөгшдийнх өсөхөөр байна. Манай улс “Хүн ам зүйн цонх”-ны үед улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын орлого, амьжиргааг дээшлүүлэх, улмаар хүн амын өсөлтийг дэмжих арга хэмжээ авч, энэ үеийг оновчтой ашиглах олон талт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй. Нөгөө талаас ойрын 10 орчим жилийн хугацааны хүн амын тэтгэвэр, тэтгэмжид зарцуулах зардал хамгийн бага байх бололцоотой энэ үед хөрөнгө оруулалтын төслүүдийг үр ашигтай хэрэгжүүлэх, 2020 оноос эрчимтэй нэмэгдэх ахмад настны нийгмийн хамгаалалд зарцуулах төсвийн суурийг бүрдүүлэх, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг даруйхан хэрэгжүүлж эхлэх шаардлага бий болсныг тооцооны үр дүнгээс харж болно.

ХҮСНЭГТ 4.2.5. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, “1Б”, “2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Он	“1Б” хувилбар					“2Б” хувилбар				
	Голч нас	Хөгшрөл-тийн индекс	Хүн ам зүйн ачаалал			Голч нас	Хөгшрөл-тийн индекс	Хүн ам зүйн ачаалал		
			Нийт	Хүүхэд	Хөгшид			Нийт	Хүүхэд	Хөгшид
2010	25.7	13.7	46.7	41.1	5.6	25.8	13.6	45.0	39.6	5.4
2011	26.1	13.8	46.4	40.7	5.6	26.2	13.6	45.0	39.6	5.4
2012	26.6	14.0	46.2	40.5	5.7	26.6	13.7	45.0	39.6	5.4
2015	27.8	14.4	46.4	40.5	5.8	27.6	14.0	46.1	40.4	5.6
2020	29.9	16.1	48.4	41.7	6.7	29.5	15.4	49.1	42.6	6.6
2025	31.6	23.1	47.1	38.3	8.8	30.9	21.8	48.6	39.9	8.7
2030	33.2	33.2	46.2	34.6	11.5	32.2	31.6	47.1	35.8	11.3
2035	34.2	44.0	46.3	32.1	14.1	32.8	41.9	46.9	33.1	13.8
2040	34.5	53.0	48.8	31.9	16.9	33.3	50.0	49.4	32.9	16.5

Хүн амыг насны хувьд таллан хувааж байгаа зааг насыг голч нас гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, 2010 онд манай улсын нутаг дэвсгэр дэх хүн амын 50 хувь нь 25.7 наснаас доош, 50 хувь нь түүнээс дээш насныхан байгаа бол “2Б” хувилбараар уг үзүүлэлт 25.8 байна. Харин 2040 онд “1Б”, “2Б” хувилбараар голч нас тус тус 34.5, 33.3 болж нэмэгдэх аж.


Олон улсын туршилтад голч нас 20-иос доош бол тухайн улсын хүн амыг залуу насны бүтэцтэй, 30-аас дээш бол хөгшин, 20-29 бол завсрын буюу “идэр” насны бүтэцтэй гэж үзэж болно³. Үүнээс дүгнэхэд манай улсын хүн ам 2025 оноос эхлэн хөгшин насны бүтэцтэй болох урьдач нөхцөл бүрдэж эхлэхээр байна.

³ Якоб С.Сийгел, Давид А.Свансон, Хүн ам зүйн арга ба материалууд, Хянан тохиолдуулсан хоёрдугаар хэвлэл, 159 дүгээр тал.

4.3. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ


Манай Улсын төрөлтийн ерөнхий коэффициент “1Б” хувилбараар 2010 онд 22.4 байснаа 2040 онд 15.7 болж 6.7 пунктээр буурахаар байна. Тооцооны “2Б” хувилбараар 2040 онд төрөлтийн ерөнхий коэффициент “1Б” хувилбарын түвшинтэй ойролцоо гарчээ. Төрөөс төрөлтийг дэмжих талаар дорвитой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь тооцоонуудаас харагдаж байна.

ЗУРАГ 4.3.1. ТӨРӨЛТИЙН ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЕНТ, “1Б”, “2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН




Нас баралтын ерөнхий коэффициент 2010 онд “1Б” хувилбараар 6.0, “2Б” хувилбараар 5.8 байна. Харин 2040 онд “1Б” хувилбараар 8.1, “2Б” хувилбараар 7.8 байхаар байна. Одоогоор Монгол Улсын хүн ам идэр насны бүтэцтэй байгаа бол 2040 онд насны бүтэц хөгширч, улмаар нас баралтын түвшин нэмэгдэхээр байна.

ЗУРАГ 4.3.2. НАС БАРАЛТЫН ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЕНТ, “1Б”, “2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН



Гадаад шилжих хөдөлгөөний мэдээллийг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоог үндэслэсэн тооцоонд ашигласныг дээр дурдсан. Тооцооны үр дүнгээр гадаад цэвэр шилжих хөдөлгөөн тогтвортой буурах хандлагатай байна.

ЗУРАГ 4.3.3. ГАДААД ЦЭВЭР ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЕНТ, “15” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН



4.4. ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ХҮН АМЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Хүн амын хөгжил, нийгэм, эдийн засгийн төлөвлөлт, тооцоо, судалгаанд түгээмэл хэрэглэгддэг зорилтот бүлгийн хүн амыг улс орон бүр өөрийн орны онцлогт тохируулан янз бүрээр тодорхойлдог. Улс орны ирээдүйн бодлого, хөтөлбөрт хамгийн чухал байж болох дараах зорилтот бүлгийн хүн амын тооны өөрчлөлтийг авч үзлээ. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэх насны хүний тоо
2. Тэтгэврийн насны хүний тоо
3. Хөдөлмөрийн насанд шинээр орох насны хүн ам
4. Тэтгэвэр тогтоолгох насанд шилжих насны хүн ам
5. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо
6. Төрөх хүүхдийн тоог оруулав.

“Бага дунд боловсролын тухай” хуулийн 3-р бүлгийн 12.4-т “Ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлнэ” гэж заасныг үндэслэн дээрх насны хүүхдийн тоо 2040 он хүртэл хэрхэн өөрчлөгдөх талаар авч үзлээ. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэн орох нас буюу 6 настай хүүхдийн тоо “15” хувилбараар 2010 онд 43001 байсан бол 2040 онд 56291 болж нэмэгдэнэ гэсэн тооцоо гарлаа. Түүнээс гадна 2010-2016 хүртэл сургуулийн насны хүүхдийн тоо огцом өсөх хандлагатай байгааг анхаарч боловсролын байгууллагад багшлах боловсон хүчин, материаллаг бааз, анги танхим зэрэг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай болох юм.

ХҮСНЭГТ 4.4.1. НЭГДҮГЭЭР АНГИД ЭЛСЭН ОРОХ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР,
"1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Он	"1Б" хувилбар				"2Б" хувилбар			
	Нийт хүн амд эзлэх хувь	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт хүн амд эзлэх хувь	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2010	1.6	43 001	21 916	21 085	1.6	43 649	22 241	21 408
2011	1.7	45 707	23 280	22 427	1.7	46 386	23 621	22 765
2012	1.8	49 524	25 198	24 326	1.8	50 270	25 570	24 700
2015	2.1	62 037	31 432	30 605	2.1	62 660	31 735	30 925
2020	1.9	60 482	30 634	29 848	2.0	63 823	32 317	31 506
2025	1.8	59 286	30 033	29 253	1.8	61 706	31 253	30 453
2030	1.5	55 271	28 016	27 255	1.6	56 826	28 797	28 029
2035	1.4	53 435	27 109	26 326	1.4	54 452	27 620	26 832
2040	1.4	56 291	28 585	27 706	1.5	57 754	29 322	28 432

"Хөдөлмөрийн тухай" хуулийн 8-р бүлгийн 109-р зүйлд "16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй" гэж заасны дагуу хөдөлмөрийн насанд шилжих 16 нас, "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуулийн 2 бүлгийн 4-р зүйлд "Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно" гэж заасныг үндэслэн хөдөлмөрийн наснаас гарах насыг эрэгтэй 60, эмэгтэй 55 насаар авлаа.

ХҮСНЭГТ 4.4.2. ХӨДӨЛМӨРИЙН НАСАНД ОРОХ БОЛОН ГАРАХ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, "1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Он	Хөдөлмөрийн насанд орох хүн ам		Хөдөлмөрийн наснаас гарах хүн ам		Зөрүү
	Нийт хүн амд эзлэх хувь	16 настай хүн ам	Нийт хүн амд эзлэх хувь	54 настай эмэгтэй, 59 настай эрэгтэй	
"1Б" хувилбар					
2010	1.9	49 571	0.6	16 073	33 498
2011	1.8	48 934	0.7	17 564	31 370
2012	1.8	48 658	0.7	19 104	29 554
2015	1.6	46 045	0.8	23 778	22 267
2020	1.4	43 162	1.0	30 050	13 112
2025	1.8	62 157	1.0	34 977	27 180
2030	1.7	60 618	1.1	39 819	20 799
2035	1.6	59 433	1.2	44 953	14 480
2040	1.4	55 527	1.3	52 254	3 273
"2Б" хувилбар					
2010	1.9	50 925	0.6	16 253	34 672
2011	1.8	50 184	0.6	17 692	32 492
2012	1.8	49 764	0.7	19 184	30 580
2015	1.6	46 660	0.8	23 760	22 900
2020	1.4	43 510	0.9	29 689	13 821
2025	1.8	62 489	1.0	34 140	28 349
2030	1.8	63 669	1.1	38 432	25 237
2035	1.6	61 575	1.1	42 865	18 710
2040	1.4	56 715	1.3	49 851	6 864

Хөдөлмөрийн насанд шилжиж байгаа хүний тоо "1Б" хувилбарын тооцоогоор 2010 онд 49 571 байсан бол хөдөлмөрийн наснаас гарч байгаа хүний тоо 16 073 болж, эдгээрийн зөрүү 33 498 хүн байна. Цаашид энэ зөрүү буурсаар 2040 он гэхэд 3 273 болж, 2010 онтой харьцуулбал 10.2 дахин багасна. Харин "2Б" хувилбарын тооцоогоор хөдөлмөрийн насанд орж байгаа болон гарч байгаа хүний тооны зөрүү 2010 онд 34 672 байгаа бөгөөд цаашид буурсаар 2035 онд 18 710 болсон бол 2040 онд 6 864 болж, 2010 онтой харьцуулбал 5.0 дахин багасна.

Хэрвээ хөдөлмөрийн насыг өөрчлөхгүй энэ хэвээр байлгавал хөдөлмөрийн наснаас гарч буй хүний тоо, хөдөлмөрийн насанд шилжих насны хүн амын тооноос давах хандлага ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 4.4.3. ТЭТГЭВРИЙН НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР,
"1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Он	"1Б" хувилбар				"2Б" хувилбар			
	Нийт хүн амд эзлэх хувь	Бүгд	60, түүнээс дээш насны эрэгтэй	55, түүнээс дээш насны эмэгтэй	Нийт хүн амд эзлэх хувь	Бүгд	60, түүнээс дээш насны эрэгтэй	55, түүнээс дээш насны эмэгтэй
2010	7.2	188 743	64 464	124 279	6.9	189 783	64 678	125 105
2011	7.1	191 497	102 770	88 727	6.9	192 090	103 030	89 060
2012	7.6	207 087	67 761	139 326	7.3	207 622	67 767	139 855
2015	8.2	236 108	130 446	105 662	7.9	235 175	129 567	105 608
2020	10.5	331 246	104 414	226 832	10.2	328 429	102 874	225 555
2025	12.6	424 476	223 303	201 173	12.1	415 377	216 138	199 239
2030	15.3	548 332	183 008	365 324	14.9	535 761	176 148	359 613
2035	17.5	659 633	335 153	324 480	16.9	635 105	316 555	318 550
2040	20.0	791 136	273 151	517 985	19.4	761 718	256 858	504 860

Тэтгэврийн насны хүн ам 2010 онд хүн амын 7 орчим хувийг эзэлж байсан бол 2020 онд 10, 2040 онд 20 орчим хувь болохоор байна. Эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдээс илүү, мөн тэтгэвэрт гарах нас 5 насаар залуу байдагтай холбоотойгоор эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин илүү байна. Тэтгэврийн насны хүн амын тоо 2010 онд 189.0 мянга орчим байсан бол 2040 онд 4 дахин өсөхөөр тооцоо гарчээ. Ийнхүү 30 жилийн дараа манай улсын хүн амын 20 хувь нь тэтгэврийн насныхан болсон байхаар тооцоо гарч байгаа нь тэтгэвэр, өндөр настны нийгмийн халамжийн үйлчилгээний ачааллыг зохицуулах, тэтгэвэрт гарах насыг өөрчлөх зэрэг бодлогын арга хэмжээ авах шаардлага гарахыг үгүйсгэхгүй юм.

Хөдөлмөрийн насны хүн амын тоог өөрийн орны онцлогт тохируулан (эрэгтэй 16-59, эмэгтэй 16-54 насаар) хүн ам зүйн ачааллыг тооцвол дараах байдалтай байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоонд үндэслэсэн "1Б" хувилбараар хүн ам зүйн ачаалал 2010 онд 58.8, үүний дотор хүүхдийнх 47.4, хөгшдийнх 11.4 байна. Хүүхдийн ачаалал 2040 онд 39.9 хувь болж, 2010 оны түвшнээс 7.8 пунктээр буурсан бол хөгшдийн ачаалал 35.0 болж, 3.5 дахин өссөн нь нийт ачааллыг 74.9 хувь болгохоор байна. Харин "2Б" хувилбарын тооцоогоор нийт ачаалал 2010 онд 54.3 хувь байснаа 2040 онд 69.2 хувь болохоор байна.

**ХҮСНЭГТ 4.4.4. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМААР ТООЦСОН АЧААЛАЛ,
"1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН**

Он	"1Б" хувилбар			"2Б" хувилбар		
	Нийт	Хүүхэд	Хөгшид	Нийт	Хүүхэд	Хөгшид
2010	58.8	47.4	11.4	54.3	45.6	8.6
2011	58.4	47.1	11.3	54.3	45.6	8.7
2012	58.8	46.8	12.0	54.5	45.6	8.9
2015	60.0	46.9	13.1	56.3	46.6	9.7
2020	66.9	49.3	17.5	63.1	50.1	12.9
2025	68.3	47.1	21.2	65.5	48.7	16.8
2030	68.7	42.8	25.8	64.6	44.2	20.4
2035	69.8	40.0	29.8	65.3	41.1	24.2
2040	74.9	39.9	35.0	69.2	41.1	28.1

Нөхөн үржихүйн нас болох 15-49 насны эмэгтэйчүүдийн нийт хүн амд эзлэх хувь 2 хувилбараар 2010 онд 30 орчим хувь байснаа 2040 онд 24 орчим хувь болж буурч байгаа хэдий ч бодит тоогоороо өсч байна. "1Б", "2Б" хувилбарын тооцоогоор дээрх насны эмэгтэйчүүдийн тоо 2040 онд харгалзан 931.7, 946.0 мянга болж, 2010 оноос тус тус 20.1, 14.7 хувиар өсөх дүн гарчээ.

**ХҮСНЭГТ 4.4.5. НӨХӨН ҮРЖИХҮЙН НАСНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТОО,
"1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН**

Он	"1Б" хувилбар		"2Б" хувилбар	
	Нийт хүн амд эзлэх хувь	Хүн амын тоо	Нийт хүн амд эзлэх хувь	Хүн амын тоо
2010	29.4	775 482	30.1	824 501
2011	29.3	785 857	29.9	832 732
2012	29.1	795 403	29.6	840 057
2015	28.2	817 469	28.7	855 324
2020	26.6	838 216	26.9	865 431
2025	26.1	881 793	26.3	899 152
2030	25.7	919 433	26.0	935 962
2035	25.0	941 385	25.4	956 493
2040	23.6	931 688	24.0	946 033

Жил бүр төрөх хүүхдийн тоо "1Б" болон "2Б" хувилбарын тооцоогоор 2010 онд харгалзан 58860, 63278 байгаа бол аажим өссөөр 2040 онд 62075, 64893 болохоор байна.

ХҮСНЭГТ 4.4.7. ТӨРӨХ ХҮҮХДИЙН ТОО,
"1Б", "2Б" ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Он	"1Б" хувилбар		"2Б" хувилбар	
	Нийт хүн амд эзлэх хувь	Төрөлтийн тоо	Нийт хүн амд эзлэх хувь	Төрөлтийн тоо
2010	2.2	58 860	2.3	63 278
2011	2.2	60 275	2.3	64 570
2012	2.2	61 472	2.3	65 618
2015	2.1	61 655	2.2	65 234
2020	1.9	59 239	1.9	61 843
2025	1.6	54 879	1.7	56 623
2030	1.5	54 702	1.6	55 980
2035	1.6	58 529	1.6	60 467
2040	1.6	62 075	1.6	64 893

Дээрх тооцооноос жил бүр төрөх нялхсын тоо өсөх тутамд эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах, боловсон хүчнийг бэлтгэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

4.5. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХЭТИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН

Аймаг, нийслэлийн хүн амын хэтийн тооцооны "1Б", "2Б" хувилбарын үр дүнгээс харахад Улаанбаатараас хот, Дархан-Уул, Баян-Өлгий, Орхон, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь аймгийн хүн амын тоо тогтмол өсч, бусад аймгийнх буурах төлөвтэй байна. Харин Өмнөговь аймгийн хэтийн тооцоо нэлээн онцлогтой. Тухайлбал, тус аймаг уруу чиглэсэн ажиллах хүчний урсгалын нөлөөгөөр суурь оны хүн амд, ялангуяа 15-39 насны эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь цаашид ч гэсэн хэвээр хадгалагдахаар байна.

Аймаг, нийслэлийн хүн амын "1Б" хувилбарын хэтийн тооцоогоор 2010-2040 он хүртэлх жилийн дундаж өсөлтийн хурд хамгийн өндөр нь Улаанбаатар (3.8 хувь), Өмнөговь (3.1 хувь), Орхон (2.5 хувь), хамгийн бага нь Завхан (-1.7 хувь), Булган, Дундговь (-1.1 хувь) аймгууд байна.

ХҮСНЭГТ 4.5.4. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ХЭТИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН,
“1Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Аймаг, нийслэл	Хүн амын тоо				Жилийн дундаж өсөлтийн хувь		
	2010	2020	2030	2040	2010-2020	2020-2030	2030-2040
Улсын түвшин	2 633 312	3 151 086	3 576 877	3 946 997	2.0	1.4	1.0
Баруун бүс	351 271	326 366	308 827	309 404	-0.7	-0.5	0.0
Баян-Өлгий	84 423	86 974	91 849	102 619	0.3	0.6	1.2
Говь-Алтай	53 144	47 171	40 955	35 934	-1.1	-1.3	-1.2
Завхан	65 238	51 451	39 597	31 144	-2.1	-2.3	-2.1
Увс	75 797	71 992	70 321	72 460	-0.5	-0.2	0.3
Ховд	72 668	68 778	66 105	67 246	-0.5	-0.4	0.2
Хангайн бүс	512 355	514 601	512 415	520 929	0.0	0.0	0.2
Архангай	83 827	77 630	71 975	68 895	-0.7	-0.7	-0.4
Баянхонгор	75 394	71 665	66 502	62 327	-0.5	-0.7	-0.6
Булган	53 240	48 358	42 339	36 281	-0.9	-1.2	-1.4
Өвөрхангай	100 009	95 622	91 399	90 779	-0.4	-0.4	-0.1
Хөвсгөл	113 636	114 218	112 327	111 947	0.1	-0.2	0.0
Орхон	86 250	107 109	127 874	150 700	2.4	1.9	1.8
Төвийн бүс	437 859	462 503	482 653	510 569	0.6	0.4	0.6
Дорноговь	57 243	66 570	75 371	86 787	1.6	1.3	1.5
Дундговь	38 651	33 959	29 513	25 863	-1.2	-1.3	-1.2
Өмнөговь	59 969	77 258	96 440	116 464	2.9	2.5	2.1
Сэлэнгэ	95 219	95 741	95 197	97 884	0.1	-0.1	0.3
Төв	83 745	75 613	66 393	58 643	-1.0	-1.2	-1.2
Дархан-Уул	90 075	99 058	104 426	108 219	1.0	0.5	0.4
Говьсүмбэр	12 957	14 303	15 314	16 708	1.0	0.7	0.9
Зүүн бүс	184 732	178 819	169 824	164 412	-0.3	-0.5	-0.3
Дорнод	68 841	67 245	62 863	58 076	-0.2	-0.7	-0.8
Сүхбаатар	50 864	48 731	46 452	45 706	-0.4	-0.5	-0.2
Хэнтий	65 027	62 842	60 509	60 630	-0.3	-0.4	0.0
Улаанбаатар	1 147 095	1 668 797	2 103 158	2 441 683	4.5	2.6	1.6

“2Б” хувилбарын тооцоогоор 2010-2040 он хүртэлх жилийн дундаж өсөлтийн хувь хамгийн өндөр нь Улаанбаатар, Өмнөговь (3.2 хувь), Орхон (2.4 хувь), хамгийн бага нь Завхан (-1.8 хувь), Булган (-1.2 хувь), Дундговь, Говь-Алтай (-1.1 хувь) аймгууд байна. Түүнчлэн, 2040 онд Улаанбаатар, Өмнөговь аймгийн хүн ам одоогийнхоос 2 дахин өсөх бол Завхан аймгийн хүн ам 2 дахин буурах тооцоо гарч байгаа нь шилжих хөдөлгөөнөөс хамаарч байна.

ХҮСНЭГТ 4.5.5. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ХЭТИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН,
“2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Аймаг, нийслэл	Хүн амын тоо				Жилийн дундаж өсөлтийн хувь		
	2010	2020	2030	2040	2010-2020	2020-2030	2030-2040
Улсын түвшин	2 739 001	3 216 543	3 593 599	3 935 473	1.7	1.2	1.0
Баруун бүс	355 987	329 162	309 286	308 958	-0.8	-0.6	0.0
Баян-Өлгий	87 136	90 694	96 272	108 371	0.4	0.6	1.3
Говь-Алтай	53 513	47 176	40 634	35 446	-1.2	-1.4	-1.3
Завхан	65 794	51 535	39 360	30 770	-2.2	-2.4	-2.2
Увс	76 246	71 197	68 069	68 950	-0.7	-0.4	0.1
Ховд	73 297	68 560	64 952	65 422	-0.6	-0.5	0.1
Хангайн бүс	518 817	519 163	514 084	521 846	0.0	-0.1	0.2
Архангай	84 335	78 967	73 710	71 398	-0.6	-0.7	-0.3
Баянхонгор	75 791	71 432	65 656	61 078	-0.6	-0.8	-0.7
Булган	53 856	47 559	40 410	33 761	-1.2	-1.5	-1.6
Өвөрхангай	100 870	96 438	91 973	91 524	-0.4	-0.5	0.0
Хөвсгөл	114 230	113 878	110 990	109 866	0.0	-0.3	-0.1
Орхон	89 735	110 889	131 345	154 219	2.4	1.8	1.7
Төвийн бүс	446 299	469 434	487 077	514 317	0.5	0.4	0.6
Дорноговь	57 906	67 217	75 914	87 419	1.6	1.3	1.5
Дундговь	38 928	34 016	29 366	25 624	-1.3	-1.4	-1.3
Өмнөговь	60 419	78 417	97 939	118 995	3.0	2.5	2.1
Сэлэнгэ	96 944	96 199	94 565	96 410	-0.1	-0.2	0.2
Төв	85 037	76 816	67 405	59 663	-1.0	-1.2	-1.1
Дархан-Уул	93 954	102 331	106 490	109 422	0.9	0.4	0.3
Говьсүмбэр	13 111	14 437	15 398	16 784	1.0	0.7	0.9
Зүүн бүс	186 175	177 323	165 568	158 436	-0.5	-0.7	-0.4
Дорнод	69 563	66 077	59 955	54 038	-0.5	-0.9	-1.0
Сүхбаатар	51 111	48 990	46 608	46 004	-0.4	-0.5	-0.1
Хэнтий	65 501	62 257	59 005	58 394	-0.5	-0.5	-0.1
Улаанбаатар	1 231 723	1 721 461	2 117 584	2 431 916	4.0	2.3	1.5

Аймаг, нийслэлийн хүн амын хэтийн тооцооны “1Б” хувилбараар хүйсийн харьцаа бүсийн болон аймгийн түвшинд харилцан адилгүй байна. Тухайлбал, 2010 онд Баруун бүс 100.5 бол Төвийн бүс 106.7 байна. Уг үзүүлэлт 2040 он гэхэд Баруун бүс 95.4 болж 2010 оны түвшнээс 5.1 пунктээр буурахаар байна. Бусад бүс мөн адил 2010 оны түвшнээс буурахаар дүн гарсан байна.

ХҮСНЭГТ 4.5.6. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, АЙМАГ, НИЙСЛЭЛ,
“1Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Аймаг, нийслэл	2010	2015	2020	2025	2030	2035	2040
Улсын түвшин	98.5	98.1	97.6	97.0	96.4	95.9	95.6
Баруун бүс	100.5	100.2	99.7	98.7	97.6	96.4	95.4
Баян-Өлгий	100.2	100.1	100.0	99.7	99.2	98.7	98.2
Говь-Алтай	100.0	99.9	98.9	96.8	94.0	90.7	87.4
Завхан	100.6	99.9	98.1	95.6	92.7	89.5	86.5
Увс	99.5	98.5	97.7	96.6	95.3	94.0	92.9
Ховд	101.9	102.5	103.1	103.3	103.3	103.0	102.8
Хангайн бүс	100.0	99.8	99.0	97.6	95.8	93.9	92.1
Архангай	99.6	99.9	99.6	99.1	98.1	97.1	96.1
Баянхонгор	101.0	101.2	100.4	98.7	96.3	93.4	90.4
Булган	106.0	106.9	107.7	108.4	109.1	109.7	110.5
Өвөрхангай	100.4	101.0	100.8	100.1	99.3	98.4	97.5
Хөвсгөл	99.2	98.5	97.1	94.7	91.6	88.3	85.1
Орхон	96.7	95.6	94.5	93.0	91.6	90.2	89.2
Төвийн бүс	106.7	108.4	107.0	104.8	102.0	99.4	96.8
Дорноговь	102.1	101.3	99.7	97.0	93.4	89.4	85.7
Дундговь	103.2	103.7	103.3	101.9	99.4	96.3	93.2
Өмнөговь	133.7	149.5	140.4	130.6	121.0	115.3	109.4
Сэлэнгэ	103.7	103.3	102.6	101.6	100.3	99.0	97.7
Төв	109.2	108.3	106.6	104.2	101.0	97.4	93.7
Дархан-Уул	96.7	96.4	96.0	95.4	94.9	94.6	94.6
Говьсүмбэр	106.4	107.8	108.1	107.8	106.2	103.9	101.5
Зүүн бүс	103.5	104.1	104.1	103.7	103.0	102.1	101.4
Дорнод	102.0	102.1	102.0	101.7	101.3	101.1	101.0
Сүхбаатар	104.1	104.4	104.0	102.8	101.1	99.1	97.3
Хэнтий	104.5	105.9	106.5	106.6	106.2	105.5	104.9
Улаанбаатар	93.6	93.3	93.7	94.2	94.7	95.2	95.7

Монгол Улсын хүн амаар тооцсон “2Б” хувилбарын тооцоогоор хүйсийн харьцаа “1Б” хувилбартай ойролцоо гарсан байна.

ХҮСНЭГТ 4.5.7. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, АЙМАГ, НИЙСЛЭЛ,
“2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Аймаг, нийслэл	2010	2015	2020	2025	2030	2035	2040
Улсын түвшин	98.1	97.3	96.6	95.8	95.1	94.5	94.1
Баруун бүс	100.7	100.2	99.5	98.4	97.0	95.7	94.6
Баян-Өлгий	100.5	100.0	99.7	99.1	98.4	97.7	97.2
Говь-Алтай	100.3	100.2	99.1	97.0	94.2	90.9	87.6
Завхан	101.2	100.4	98.7	96.3	93.4	90.3	87.2
Увс	99.5	98.1	97.1	95.6	94.1	92.6	91.4
Ховд	102.2	102.4	102.6	102.6	102.2	101.8	101.5
Хангайн бүс	100.0	99.7	98.6	97.1	95.2	93.3	91.5
Архангай	99.7	99.9	99.4	98.8	97.8	96.7	95.8
Баянхонгор	101.1	101.1	100.2	98.5	96.0	93.1	90.2
Булган	105.9	106.5	106.9	107.3	107.7	108.2	108.9
Өвөрхангай	100.8	101.4	101.2	100.4	99.6	98.7	97.9
Хөвсгөл	99.2	98.4	96.8	94.3	91.2	87.9	84.7
Орхон	96.3	94.9	93.6	92.0	90.4	89.0	88.0
Төвийн бүс	106.4	107.9	106.3	103.9	101.0	98.3	95.7
Дорноговь	101.8	100.8	99.0	96.3	92.6	88.6	84.9
Дундговь	103.3	103.7	103.1	101.7	99.1	96.0	92.9
Өмнөговь	133.6	148.6	139.1	129.1	119.4	113.5	108.0
Сэлэнгэ	103.5	102.9	102.0	100.7	99.2	97.7	96.4
Төв	108.9	107.8	106.0	103.4	100.2	96.4	92.8
Дархан-Уул	96.6	96.0	95.3	94.6	93.8	93.4	93.4
Говьсүмбэр	106.1	107.4	107.5	107.0	105.4	103.0	100.5
Зүүн бүс	103.4	103.7	103.5	102.9	101.9	100.9	100.2
Дорнод	102.0	101.7	101.2	100.7	100.1	99.7	99.7
Сүхбаатар	104.0	104.0	103.4	102.0	100.1	98.1	96.3
Хэнтий	104.4	105.6	106.1	106.0	105.3	104.4	103.8
Улаанбаатар	92.9	92.1	92.3	92.6	92.9	93.3	93.9

Аймаг, нийслэлийн хүн амын хэтийн тооцооны “1Б”, “2Б” хувилбараар хүн ам зүйн ачаалал аймаг, нийслэл, бүсийн түвшинд харилцан адилгүй байна. Аймаг бүрийн хүн ам зүйн ачааллыг (хүснэгт 4.5.3)-аас харна уу. Хүүхэд болон хөгшдийн хүн ам зүйн ачааллыг хавсралтад оруулав.


ХҮСНЭГТ 4.5.8. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, АЙМАГ, НИЙСЛЭЛ,
“1Б”, “2Б” ХУВИЛБАРААР, 2010-2040 ОН

Аймаг, нийслэл	“1Б” хувилбар				“2Б” хувилбар			
	2010	2020	2030	2040	2010	2020	2030	2040
Улсын түвшин	46.7	48.4	46.2	48.8	45.0	49.1	47.1	49.4
Баруун бүс	61.6	56.8	56.1	66.1	60.5	57.7	57.2	66.0
Баян-Өлгий	68.4	62.0	60.6	68.8	65.5	63.0	61.8	67.1
Говь-Алтай	54.5	48.3	47.9	59.8	53.9	48.3	47.8	59.6
Завхан	57.4	53.1	51.6	69.5	56.7	52.8	51.1	68.7
Увс	61.3	58.4	58.5	64.5	60.8	60.0	60.4	66.0
Ховд	63.8	57.9	55.9	65.7	63.0	59.3	57.5	66.7
Хангайн бүс	52.9	49.8	49.2	58.9	52.0	50.7	50.2	59.5
Архангай	54.9	51.1	50.2	59.1	54.5	54.4	53.9	62.0
Баянхонгор	55.6	51.0	48.6	58.2	55.2	51.0	48.7	58.3
Булган	50.9	44.7	43.7	53.4	50.2	46.4	45.9	56.1
Өвөрхангай	56.8	53.0	51.0	62.6	56.1	54.0	52.2	63.4
Хөвсгөл	54.0	51.0	50.7	63.7	53.6	51.1	50.8	63.8
Орхон	44.3	46.4	48.3	54.9	42.4	46.6	48.6	54.4
Төвийн бүс	48.1	46.6	46.2	55.9	47.2	46.6	46.3	55.7
Дорноговь	48.8	49.7	47.5	57.3	48.3	49.9	47.6	57.1
Дундговь	57.9	50.1	51.2	65.4	57.4	50.1	51.2	65.3
Өмнөговь	42.4	33.8	38.9	51.0	42.2	36.1	41.6	52.8
Сэлэнгэ	49.0	49.7	49.1	60.8	48.0	47.4	46.6	58.4
Төв	50.6	50.2	49.5	63.7	49.7	49.8	48.9	62.4
Дархан-Уул	44.2	47.9	46.2	49.7	42.3	47.8	46.3	49.7
Говьсүмбэр	52.3	53.5	48.9	59.7	51.6	53.4	48.7	59.1
Зүүн бүс	51.0	49.4	47.6	56.0	50.6	50.2	48.7	57.4
Дорнод	48.6	49.4	45.8	50.7	48.1	51.5	48.5	53.8
Сүхбаатар	49.9	47.5	46.7	57.2	49.6	49.0	48.6	58.7
Хэнтий	54.6	50.9	50.1	60.5	54.2	49.7	49.1	59.9
Улаанбаатар	39.2	46.9	44.0	43.1	37.0	47.8	45.1	43.9



Хүмүүнд төр эрхэм. Төрд хүмүүн эрэгнэ

ДҮГНЭЛТ



ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хүн амын хэтийн тооцооны үр дүнгээс дараах гол дүгнэлтүүд гарч байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоонд суурилсан хэтийн тооцооны төрөлтийн дундаж бууралттай “1Б” хувилбараар хүн амын тоо 2017 онд 3 сая, 2040 онд 3.9 саяд хүрнэ. Харин Монгол Улсын хүн амын тоонд суурилсан, төрөлтийн дундаж бууралттай “2Б” хувилбараар хүн амын тоо 2016 онд 3 сая, 2040 онд 3.9 саяд хүрэхээр байгаа нь ойрын 30 жилд манай улсын хүн амын тоо тасралтгүй өсөхийг илтгэнэ. Гэвч хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд буурч, “1Б” хувилбараар 2010-2040 онд 1.9-0.8 хувь, “2Б” хувилбараар мөн хугацаанд 1.7-0.9 хувь болох хандлага ажиглагдаж байна.

Хүн амын нас, хүйсийн бүтцэд нэлээд өөрчлөлт гарахаар байна. Тухайлбал, хүн амын хэтийн тооцооны “1Б” хувилбарын үр дүнгээр 0-14 насны хүн амын эзлэх хувь 2010 онд 28.0 хувь байснаа 2015 он хүртэл буурч, харин 2020 он хүртэл эргэн өсч (28.1 хувь), цаашид буурсаар 2040 онд 21.4 хувь болно. Харин 65-аас дээш насныхны эзлэх хувь 2010 онд 3.8 хувь байснаа аажим өссөөр 2040 онд 11.4 хувь болж, бараг 3 дахин нэмэгдэх юм. Өөрөөр хэлбэл, аль ч хувилбараар авч үзсэн хүн амын насны бүтэц 2030 оны сүүлийн хагасаас эхлэн “хөгшин” болох төлөвтэй байна.

Хүн ам зүйн ачаалал “1Б” хувилбарын тооцоогоор 2010 онд 46.7 байсан бол 2040 онд 48.8 болж, 2.1 пунктээр (“2Б” хувилбараар 2010 онд 45.0, 2040 онд 49.4 болно) өснө. Хэдийгээр энэхүү өсөлт 30 жилийн хугацаанд харьцангуй бага боловч бүтцээр нь нарийвчилж авч үзвэл хөгшчүүдийн ачаалал бараг 3 дахин нэмэгдэхээр байна. Нөгөө талаас ирээдүйн хөдөлмөрийн зах дээрх ажиллах хүчний нийлүүлэлт харьцангуй тогтвортой байх (“1Б” хувилбараар 15-64 насны хүн ам 2010 онд 68.2 хувь, 2040 онд 67.3 хувь, “2Б” хувилбараар мөн насныхан 2010 онд 69.0 хувь, 2040 онд 66.9 хувь болно) боловч 2010 онд “тэжээгч” 3 хүн тутмын 1-ийг бүрдүүлдэг байсан 40-64 насныхан 2040 он гэхэд 5 харьцаатай болж өсөх юм. Тиймээс нийгмийн хамгаалал, даатгалын тогтолцооны шинэтгэлийг эрчимжүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийн сангийн орлогын суурийг одооноос бүрдүүлэх, улсын төсвийн зарцуулалтыг хөрөнгө оруулалтад чиглүүлж, ажлын байрыг олноор бий болгох хэрэгцээтэй байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс хүн амын тогтвортой өсөлтийг хангах, хүн ам зүйн цонхны үеийг үр дүнтэй ашиглахад төрийн зохицуулалт шаардлагатай байгааг тооцоо харууллаа.

Нийгмийн хөгжлийн анхаарлын төвд байх зорилтот бүлгүүдийн хүн амын тоо ч одоогийнхоос нэлээд өсөх хандлагатай байна. Тухайлбал, жил бүр сургуульд шинээр орох насны хүүхдийн тоо ойрын гурваас дөрвөн жилд эрс нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь боловсролын салбарт ихээхэн хөрөнгө оруулалт шаардагдахыг илтгэнэ.

Тэтгэврийн насны хүн амын тоо 2040 он гэхэд одоогийнхоос 3-4 дахин нэмэгдэхээр байгаа нь нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тогтолцоог одооноос бодлогоор зохицуулах шаардлага бий болгохоор байна. Өөрөөр хэлбэл, хэтийн тооцооны үр дүнг цэргийн алба хаах насны эрчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд зэрэг зорилтот бүлгээр ангилж, бодлого, төлөвлөлтдөө сайтар ашиглах нь чухал юм.

Ихэнх аймгийн хүн амын тоо өнөөгийн хурдцаар авч үзэхэд 2040 онд гэхэд буурч, Өмнөговь аймаг, Улаанбаатар хотын хүн ам 2 дахин өсөх, Завхан аймгийн хүн ам 2 дахин буурах тооцоо гарсан нь дотоод шилжих хөдөлгөөний нөлөөллөөс хамаарч байгааг анхаарч, шилжих хөдөлгөөнийг зохицуулах, төвлөрлийг сааруулах, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгаж, хөдөөд амьдрах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

НОМ ЗҮЙ


- “Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо” сэдэвчилсэн судалгаа, ҮСХ, 2003 он
- “Хүн ам, орон сууцны 2010 оын тооллого: “Хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц”, сэдэвчилсэн судалгаа, ҮСХ, 2012 он
- “Хүн ам, орон сууцны 2010 оын тооллого: Нэгдсэн дүн”, ҮСХ, 2011 он
- “Хүн амын статистик үзүүлэлт тооцох аргачлал”, ҮСХ, 2009 он
- “Хүн амын хэтийн тооцооны үзэл баримтлал”, ҮСХ, 2008 он
- “The Methods and Materials of Demography, Second Edition (2nd Edition) by David A. Swanson, Jacob S. Siegel, David Swanson, Henry S. Shryock, Published 2004



Хүмүүнд төр эрхэм. Төрд хүмүүн эргэнэ

ХАВСРАЛТ 1.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амд үндэслэсэн улсын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо, хувилбар тус бүрээр



